



# СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.02.20 №07, 08 (10684, 10685)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн хошууч Д.ОЮУНГЭРЭЛ, ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

Дугаарын сурвалжилга

## ТЭД БУУХ ЭЗЭНТЭЙ, БУЦАХ ХАЯГТАЙ ОЛОН АЖЛЫН АРД ГАРНА



(Зэвсэгт хүчний 232 дугаар ангиас бэлтгэсэн сурвалжилгыг IV нүүрнээс уншина уу)

## БНХАУ-ЫН ЦЭРГИЙН ЭМЧ, СУВИЛАГЧ НАРТ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЛЭЭ



Монгол цэргийн нэгдсэн холбооноос санаачлан БНХАУ-ын Хэбэй мужийн Ухань хотод Коронавирусийн голомтод ажиллаж

байгаа БНХАУ-ын цэргийн эмч, сувилагч нарт чин сэтгэлийн тусламж, дэмжлэг үзүүлэх ажиллагааг 2 дугаар сарын 18-ны өдөр БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны байранд зохион байгуулсан юм. Тус арга хэмжээнд Монгол цэргийн нэгдсэн холбоо, ЗХЖШ, ХХЕГ, ОБЕГ, ШШГЕГ, ҮБХИС, Цэргийн төв эмнэлэг, "Энхийн төлөө цогцолбор", "Болдтөмөр Ерөө гол" ХХК-ийн төлөөлөгчид оролцлоо.

Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Монгол цэргийн нэгдсэн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Тогоо БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цай Вэньруйд дээрх байгууллагуудын хамт олны цуглуулсан нийт 65 сая төгрөгийн хандивыг БНХАУ-д цэргийн сургууль төгсөгчид болон цэргийн эмч, сувилагчдын төлөөллийн ил захидлын хамт халдварт өвчний голомтод ажиллаж байгаа цэргийн эмч, сувилагч нарт дамжуулахыг хүсэн гардуулсан юм. Мөн тэрээр Коронавирус хэмээх тахал зөвхөн

БНХАУ-ын асуудал биш дэлхий нийтийг хамарсан гамшиг болж байгаа энэ үед "Айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг" гэж монголчуудын ярьдгаар бид мөнхийн хөршийн хувьд өөрсдийн боломжийн хэрээр тусламж, сэтгэлийн дэм үзүүлж байгаа юм гэдгийг онцлон тэмдэглэлээ.

Элчин сайд Цай Вэньруй "Хятадын ард түмэн болон цэргийн эмч, сувилагч нарт Монголын цэргийн бие бүрэлдэхүүнээс үзүүлж буй харамгүй тусламж, чин сэтгэлд талархаж байна. Энэ нь манай хоёр улсын харилцаа тэр дундаа Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа өндөр түвшинд байгааг харуулж байгаа юм. Та бүхний тусламж, дэмжлэг, сэтгэлийн үгсийг хятадын ард түмэн, цэргийн алба хаагчдад нэн даруй дамжуулах болно. Тэдний өмнөөс талархаж буйгаа илэрхийлье. Бид хамтдаа энэ аймшигт өвчний эсрэг тэмцэж ялан дийлнэ гэдэгт итгэлтэй байна" хэмээсэн юм.

### Онцлох эрхэм

## ХӨӨРӨГТ ХӨГЖМИЙН ХААН АЯЛГУУ ЭГШИГЛЭХҮЙ ДОР ...



Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгаас тодорсон олон арван гавьяат байдгийн нэг нь тус чуулгын гоцлол

хөгжимчин асан, найраг баян хуурч, хөгжмийн зохиолч, гавьяат жүжигчин Г.Тэрбиш юм. Түүний амьдрал, уран бүтээлийн талаар монголчууд бид өөрсдийн хэмжээнд мэдэх хэдий ч таван настайгаасаа хөгжим тоглож, сумын клуб, сургуулийн хооронд гүйдэг байсан, 500 гаруй хөгжмийн бүтээлийг зохиосон авьяаслаг нэгэн болохыг нь тэр бүр мэдэхгүй биз. Тэр бээр өдгөө 70 насны босгыг аль хэдийн давсан ч залуу насны эрч хүч, бүтээж туурвихын онгод хийморь дүүрэн яваа нь хэн бүхний анхаарлын төвд байдаг. Иймээс энэ л эрхмийн бахархам үйлс, бахдам амжилтын нууцыг нь бага боловч тайлах сан хэмээх сэтгэлдээ хөтлөгдөн нэгэн өдрийг хамтдаа хуучилж өнгөрүүлсэн минь энэ.

(Үргэлжлэл нь VIII нүүрт)

## "ЗЭРЭГ УРАГШИЛЪЯ" БАГ ҮЗЭГЧДИЙН САНАЛААР ТЭРГҮҮЛЭВ



Цэргийн төв эмнэлгийн "Зэрэг урагшилья" баг "25 дугаар суваг" телевизээс зохион байгуулсан "Сэрэлт-4" реалити шоу тэмцээнд амжилттай оролцож, тэргүүн байрт шалгарлаа. Нийт 10 дугаар явагдсан тус шоу тэмцээнд Цэргийн төв эмнэлэг, Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэг, Улаанбаатар төмөр замын төв эмнэлгийн багууд оролцожээ. Цэргийн төв эмнэлгийн гэмтлийн эмч, хошууч Л.Энхбаяр, мэс заслын эмч, ахмад Д.Гантулга, мэдээгүйжүүлэгч эмч, дэслэгч Ш.Бүд нар тус тэмцээнд нэг баг болж өрсөлдсөн бөгөөд үзэгчдийн саналыг хамгийн ихээр цуглуулж, тэргүүлсэн юм. Тэмцээний үеэр эмч нар алсын дуудлагад явж, өвчтөнийг яаралтай тээвэрлэх, эмнэлгүүдийн яаралтай тусламжийн төв, түргэн тусламж, сэхээн амьдруулах тасгуудад ажиллах зэрэг олон төрлийн даалгаврыг гүйцэтгэсэн байна.

"Ард түмнийхээ эрүүл энхийн манаанд цаг наргүй зүтгэж буй тэдний нөр их хөдөлмөрийн

талаар эерэг мэдээлэл өгөх, эмч нарын ур чадвар, эрүүл мэндийн дэвшилтэт шинэ техник, технологи, ололт, амжилтыг сурталчлах, эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал, өдөр тутмын үйл ажиллагааг иргэдэд таниулан эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, шинэ санал, санаачилгыг түгээн дэлгэрүүлэх зайлшгүй шаардлага гарч байгаа энэ үед тус шоуны ач холбогдол өндөр юм" хэмээн реалити шоууг санаачлагч "Эрүүл мэндийн хөгжлийн төв"-ийнхөн хэлсэн байна.

Цэргийн төв эмнэлгийн дарга-ерөнхий эмч, хурандаа С.Батболд "Тус тэмцээнд түрүүлэхэд дан ганц бидний идэвх, чармайлтаас гадна Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, ахмад дайчид, нийт бие бүрэлдэхүүний дэмжлэг, чин сэтгэлийн оролцоо чухал байсныг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Иймд мөрдэс нэгт дайчдаа Цэргийн төв эмнэлгийн нэрийн өмнөөс баярлаж талархсанаа илэрхийлье" гэв.

# Б.Нямсүрэн: "COVID-19"-ӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОЛОМЖТОЙ

Цэргийн төв эмнэлгийн халдвар судлаач эмч Б.Нямсүрэнгээс "COVID-19" буюу коронавирусийн халдварын онцлог, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зарим зүйлийг тодрууллаа.

**"COVID-19" вирусийн дэгдэлтийн талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээг бидэнд хүргэнэ үү?**

-2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар БНХАУ-аас гадна дэлхийн

байгууллагаас гаргасан зөвлөмж, зааврыг дэлхийн бүх улсын эрүүл мэндийн ажилчид дагаж мөрдөх ёстой гэсэн үг.

**Коронавирусийн халдварын онцлогийн тухай хэлнэ үү?**

сэрэмж, хувийн ариун цэврийг чандлан сахиж, олон хүнтэй газраар явахгүй байхыг зөвлөе.

**"COVID-19"-өөс Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд хэрхэн сэргийлэх ёстой вэ?**

-Зэвсэгт хүчний анги, салбарууд тэр дундаа хугацаат цэргийн алба хаагчидтай ангиуд сайтар анхаарах ёстой. Цэргийн амрах байрны агааржуулалт, цонхны салхивчийг 2-3 цаг

удирдлагууд амны хаалтын хангалт, хүрэлцээнд нь анхаараарай. "COVID-19" өөрийн гэсэн хэлбэр, хэмжээтэй. Тиймээс шаардлага хангасан амны хаалт зүүж байгаа эсэхэд нь хяналт тавих нь зүйтэй. Зах зээлд чанарын шаардлага хангахгүй амны хаалтууд ихээр зарагдаж байгаа учир сонголтдоо анхаарах нь чухал. Гэхдээ цэргүүдийг амны хаалтаар хангаад орхих бус ариун цэвэр, цэвэрлэгээнд нь анхаараарай. Амны хаалтыг зөв зүүхээс эхлээд тайлах хүртэл чухал бөгөөд амны хаалтын урд хэсэг ихээр бохирддог учир гараа бүү хүргээрэй. Тайлахдаа хоёр бүчнээс нь бариад дотогш хавсарч авах нь зөв. Цэргийн байранд хатуу савангаас илүүтэй бактерийн эсрэг шингэн саван хэрэглэх нь оновчтой. Эмнэлгийн орчин болоод олон хүнтэй газар хатуу саван хэрэглэх нь эрсдэлийг нэмэгдүүлдэг. Гар, нүүрийн алчуурын цэвэрлэгээнд ч мөн анхаарч, индүүдэж хэрэглэх шаардлагатай. Анги, байгууллагын удирдлагын зүгээс цэргийн алба хаагчдынхаа гарын ариун цэвэрээ хангах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал. Мөн гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай уусмалуудыг ангийн хүн ихээр явдаг хэсгүүдэд байрлуул. Ангийн гал тогооны орчны эрүүл ахуйн нөхцөл ч чухал. Аяга, таваг, халбага, сэрээ зэргийг халдваргүйжүүлэх бодис ашиглан гурван дамжлагат угаалгаар сайтар угааж, цэвэрлэх хэрэгтэй. Зөв ханиаж, найтааж сурах нь ч чухал. Амны хаалтгүйгээр ханиахад агаарт 40,000 гаруй шүлсний дусал цацагддаг. Ханиаж найтаахдаа бугуйныхаа дотор талаар ам, хамраа хааж найтаах хэрэгтэйг зөвлөе. Бусадтай гар барихаас

зайлсхийх, нус, цэрээ ил задгай хаяхгүй байх соёлыг хувь хүн бүр эзэмших ёстой. Ингэснээр бусдад болон өөртөө халдвар дамжихаас сэргийлнэ. Орон байрны цэвэрлэгээ, үйлчилгээнд анхаарч халдваргүйжүүлэх бодис буюу жавелины уусмалаар олон хүн орж, гардаг хаалганы бариулыг 30-40 минутын давтамжтай байнгын шүршиж арчих шаардлагатай. Халдваргүйжүүлэх бодисыг өндөр хувьтайгаар найруулан ариун цэврийн өрөө, усанд орох газрыг тогтмол угааж, цэвэрлээрэй. Коронавирусийн халдварын үед хувь хүний дархлаа маш чухал. Цэргийн алба хаагчдаа чацаргана, халуун аарц зэргийг өгөх буюу 1-2 литр шингэн зүйлийг өдөрт уулгаж, илчлэг амин дэмтэй хоолоор хангах хэрэгтэй. Энэ нь зөвхөн коронавирус ч гэлтгүй бусад халдварт өвчин, ханиад томуунаас урьдчилан сэргийлнэ.

**Анги, байгууллагын эмч нарт хандаж юу хэлэх вэ?**

-Анги, байгууллагын эмч нар сонор, сэрэмжээ өндөржүүл. Цэргийн алба хаагчдад эрүүл мэндийн үзлэгийг өдөр бүр явуулж, биеийн халуун болон амьсгалын замын шинж тэмдэг байгаа эсэхийг байнга хянаарай. Мөн Эрүүл мэндийн яамнаас болоод бусад мэргэжлийн байгууллагаас гаргаж байгаа зөвлөгөө, зөвлөмж, мэдээллийг тогтмол авч, анги, байгууллагынхаа удирдлага болон бие бүрэлдэхүүнд танилцуулж, урьдчилан сэргийлэх сургалтыг тухай бүрт зохион байгуулах хэрэгтэй. Дээрх урьдчилан сэргийлэх арга хэмжээг хүн бүр дагаж мөрдвөл тус аюулт өвчнөөс сэргийлэх боломжтой.

**Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ**



27 оронд тус өвчин тархаж, 75040 хүн халдвар авч, 2007 хүн нас бараад байна. Коронавирус өмнө нь байсан. "САРС", "МЕРС" зэрэг өвчин нь коронавирусийн нэг төрөл юм. Гэхдээ тус вирусийг шинэ төрлийн коронавирус гэж нэрлээд байгаа. Тийм учир олон улсын дүрмээр зохицуулагддаг халдварт өвчний ангилалд оруулсан. Өөрөөр хэлбэл, Дэлхийн эрүүл мэндийн

-Тус вирус нь агаар дуслын, хавьтлын замаар халдварладаг. Халдвар дамжих зам нь маш өргөн хүрээтэй учир тархац нь олон улсын хэмжээнд өндөр байна. Монгол Улсын хувьд өндөр эрсдэлтэй орны тоонд багтсан. Манай улстай хил залгаа оршдог улсуудад тус өвчлөл бүртгэгдээд байгаа учраас халдвар зөөвөрлөгдөн ирэх өндөр эрсдэлтэй байна. Иймээс хувь хүн бүр сонор

тутамд нээж, агаарын солилцоог сайжруулах хэрэгтэй. Эмнэлгийн нөхцөлд эмчлүүлэгчийн ор хоорондын зай хоёр метр байх шаардлагатай гэж үздэг. Иймд цэргүүдийн унтах ор хоорондын зайг аль болох сийрэг байхаар зохион байгуулбал тохиромжтой. Хлор агуулсан халдваргүйжүүлэх бодисоор агаарын цацлагыг байнга хийгээрэй. Мөн амны хаалтыг зүүж хэвш. Анги, байгууллагын

## Хилийн чанадаас

### Афганистан улс

## МОНГОЛ ЦЭРГҮҮД МАНЛАЙЛАВ

ИБНАУ-д явагдаж буй ХБНГУ-ын тэргүүлсэн "Шийдвэртэй дэмжлэг" олон улсын ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчдын дундуламжлал болгон зохион байгуулагддаг 25 километрийн "CAMP-MARMAL CHARITY-MARCH 2020" гүйлтийн тэмцээнд 19 орны 350 гаруй энхийг сахиулагч тэсвэр хатуужил, хурд, хүчээ сорин өрсөлдлөө.

Тэмцээнд Монголын 39 цэргийн алба хаагч оролцож өндөр амжилт үзүүлээ. Тодруулбал, тэргүүн байрт ахлагч Н.Гантулга /330/, дэд байрт дэд ахлагч Ч.Түмэнбаян /345/, гутгаар байрт ахлагч Д.Даваасүрэн /327/, эмэгтэй



цэргийн алба хаагчдын төрөлд дэд ахлагч Б.Оюунжаргал /353/, Б.Одончимэг /УБХИС/ нар

энхий байруудыг эзэлсэн юм. **Хошууч Д.ХАШХҮҮ**

## БНӨСУ

## ӨНӨӨ ЖИЛ ӨМНӨД СУДАНД...

ЗХЖШ, ЦДБЭЧ хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Цагаан сар-Монгол түмний уламжлалт их баяр" тэмцээн Өмнөд Судан улсад явагдаж гэж байна. Монгол түмний үндэсний өв соёл, дуу хуур, тоглоом наадгай, түүх шашир, утга зохиол, бичиг, соёлын өв уламжлалыг түгээн дэлгэрүүлж, сурталчлан таниулах, Зэвсэгт хүчний ангиудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зэрэг олон зорилгыг агуулдаг тус тэмцээн өнөө жил дэлхий нийтийг цочроогоод байгаа халдварт тахлаас улбаатай хорио цээрийн дэглэмээс шалтгаалан өнжих болсныг уншигч Та бүхэн анзаарсан биз ээ. Тэгвэл өнжих

бус Өмнөд Судан улсад удирдамжид заагдсан утга агуулгаа хадгалан зохион байгуулагдах гэж буйг дуулгахад таатай байна. Зэвсэгт хүчний бүхий л анги, төрийн цэргийн байгууллагуудын төлөөлөл энд үүрэг гүйцэтгэж буй учраас оролцогчдын цар хүрээ, чанар чансаа, өрсөлдөөн өнөө л эх орондоо байгаагийн адил болох нь гарцаагүй. Анги, байгууллага төлөөлөн оролцож буй багуудын бэлтгэл, идэвх зүтгэлээс энэ нь тодорхой ажиглагдаж байгаа юм. 18 дахь жилдээ зохион байгуулагдах гэж буй тус тэмцээнд Зэвсэгт хүчний 22 анги, бусад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчид оролцно.

## "ХОРТ ЗУРШЛААС ТАТГАЛЗЬЯ" УРИА ДЭВШҮҮЛЛЭЭ

Халуундулаан, эерэг уур амьсгал, цаашлаад аливаа амжилт, ялалт бүхэн энгийн зүйлээс эхэлдэг. Бие биедээ талархах, нөхдгийнхөө зөв, сайн талыг олж харах, нэгэндээ урмын үг харамгүй хэлэх, аливаад чин сэтгэлээсээ хандах, буруу зуршилтай нэгнээ шүүмжилж, залруулдаг байх гээд л... Энэ мэт хэний ч хийж чадах энгийн алхмууд нь эрүүл хамт олон, эрүүл нийгэм, эрүүл ирээдүйг цогцлоож чаддаг гэдгийг Та бодож үзсэн үү. Тэгвэл энэ бүхний эхлэл зөв хандлага, зөв манлайллын суурийг ахлах ахлагч Г.Батжаргал захирагчтай тасгийн хамт олон тавилаа. Тодотговол эдгээр залуус "Хорт зуршлаас татгалзъя" уриан дор

тамхинаас гарах аяныг өрнүүлсэн юм. Уг тасаг 11 цэргийн алба хаагчтай бөгөөд 9 нь тамхитай "нөхөрлөдөг" байсан бол энэхүү аяны үр дүнд тэдний дөрөв нь тамхийг ор тас орхиж, бусад нь өдөрт татдаг тоогоо эрс багасгажээ. Тус тасгийн залуус тун удахгүй тамхийг хамт олон болох зорилгоо биелүүлэхээ дуу нэгтгэйгээр илэрхийлж байгаагийн дээр мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэж буй батальоны хамт олноо "Хорт зуршлаас татгалзъя" урианд нэгдэж, тамхийг баталган болохыг уриаллаа.

**Ахмад Д.МЭНДБАЯР**

## Редакцын шууданд

### 015 дугаар анги

Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс ангийн байрлалд өвчний эсрэг заавар, зөвлөмжүүдийг тараан байрлуулж, ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлөөс хугацаат цэргийн алба хаагчдад таван ээлжийн нийт 300 амны хаалт оёж, тараалаа.

### 027 дугаар анги



Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх "COVID-19" буюу коронавирусийн дэгдэлтийн үед тус эмнэлгийн орнуудыг суллан, дэлгэн ажиллуулах талаар Цэргийн төв эмнэлгийн эмч нарт үүрэг, даалгавар өглөө.

### 325 дугаар анги

2019-2020 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 10 км-ийн явган маршийг байгаль, цаг агаарын хүндрүүлсэн нөхцөлд явууллаа.

**Ахмад Н.МӨНХБААТАР**

### 330 дугаар анги

Коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор Дархан-Уул аймгийн "Олон улсын худалдааны төв"-өөр үйлчлүүлж байгаа иргэдэд тус ангийн "Аавуудын групп"-ийн гишүүд болох ахлах Д.Анхбаяр, Ц.Батболд, Б.Наранболд, Б.Баатархүү, Б.Чинбат, ахлагч, Л.Энхтүвшин, Б.Бадамсэрээжид, Х.Тэгшжаргал, нараар удирдуулсан баг 500 ширхэг амны хаалтыг үнэгүй тараав. Мөн Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгийн "Цусны төв"-д цусны нөөц бүрдүүлэх зорилгоор ангийн 64 цэргийн алба хаагч, ажилтан цусаа хандивлалаа.

**Ахмад Э.ГАНЦООЖ**

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

**Тавигдах шаардлага:**  
-Батлан хамгаалах, цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдлын чиглэлээр;  
-Магистр болон түүнээс дээш зэрэгтэй;  
-Зэвсэгт хүчинд 10-аас доошгүй жил алба хаасан;  
-эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршлага, заах арга зүйтэй;  
-төрийн албан хаагчийн ёс зүй, харилцааны соёлтой, багаар ажиллах чадвартай;  
- компьютерын хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн;  
-гадаад хэлний мэдлэгтэй.  
**Бүртгэл:**  
2020 оны 2 дугаар сарын 13-наас 3 дугаар сарын 2-ны

өдрүүдэд явагдана.  
**Бүрдүүлэх материал:**  
-Бакалавр, магистр, докторын дипломын баталгаажуулсан хуулбар;  
-төрийн албан хаагчийн анкет /Маягт №1/;  
-БХЯ, ЗХЖШ-ын зөвшөөрөл;  
-иргэний үнэмлэхийн баталгаажуулсан хуулбар;  
-хоёр хувь цээж зураг;  
-бусад баримт бичгийн хуулбар;  
-бүртгэлийн хураамж.  
**Хаяг: Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 303 тоот өрөө.**

**Харилцах утас: БХЭШХ-ийн референт: 453942, 90881133.**

# ТЭДНИЙ ХУВЬД ИХ АЖЛЫН ЖИЛ БОЛНО

Өнгөргч 2019 онд Улаанбаатар хотын есөн дүүргээс үйл ажиллагаагаараа бусдыгаа манлайлж, нийслэлийн "Тэргүүний Цэргийн штаб"-аар шалгарсан хамт олон бол хурандаа Л.Мөнхбат даргатай Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб юм. "Өөдлөх айл үүднээсээ" гэдэг шиг тус Цэргийн штабын үүдээр орох төдийд дотоод тохижилт, зохион байгуулалтаасаа эхлээд аргагүй л "Тэргүүний" гэх тодотголтой болох нь анзаарагдана. Баянгол дүүргийн Засаг дарга С.Одонтуяа ч тус Цэргийн штабын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байдгаа илэрхийлсэн. Тэр бээр хэлэхдээ "Би тус дүүргийн Засаг даргаар томилогдсоноос хойш Цэргийн штабтай нягт хамтран ажиллаж байна.



Зүүн гар талаас: Дэд хурандаа С.БҮДРАГЧАА, хурандаа Л.МӨНХБАТ, дэд хурандаа Д.ЭРДЭНЭБАЯР, арын эгнээнд зүүн гар талаас хошууч Б.БАТБОЛД, дэслэгч Б.ДЭЛГЭРМАА, ахлах ахлагч Д.ДЭМБЭРЭЛБАЛЖИННЯМ



2019 оны нийслэлийн "Тэргүүний цэргийн штаб"-аар шалгарчээ



"Эх орон-36" хөтөлбөрт хамрагдаж байгаа сурагчдад жагсаалын бэлтгэл хичээлийг зааж буй нь



Хороодын Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтаар зэвсэг, техниктэй танилцуулж байгаа нь



Иргэдэд төрийн батлан хамгаалах үйлчилгээг ая тухтай, тохилог орчинд хүргэж байна



Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа албан хаагчид нийслэлийн бүтээн байгуулалтад оролцож байгаа нь



Засаг дарга С.ОДОНТУЯА

Ялангуяа, иргэд, хүүхэд, залуусыг хамруулсан үйл ажиллагаа зохион байгуулах талд ч түлхүү анхаарч ажиллахыг хүссэн. Тэд ч миний хүсэлт, шаардлагыг соргогоор мэдэрч "Эх орон-36" хөтөлбөрийг санаачлан амжилттай хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн гол зорилго нь хүүхэд, залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх, Зэвсэгт хүчин болон Хилийн цэргийн ангиудын өдөр тутмын үйл ажиллагааг танилцуулах, бие бялдар, эрүүл мэндийн боловсролыг олгоход чиглэдэг. Уг зорилгын хүрээнд Зэвсэгт хүчин, Онцгой байдал, Цагдаагийн алба хаагчид болон "Улаан загалмай" нийгэмлэг, Скаутын холбоотой хамтран сурагчдад жагсаалын бэлтгэлээс эхлээд аливаа гамшиг, ослын үед өөрийн болон нөхрийнхөө амь насыг хэрхэн авран хамгаалах, байр зүй, газрын зураг дээр хэрхэн ажиллах зэрэг олон төрлийн сургалтыг явуулдаг. Энэхүү хөтөлбөрт манай дүүргийн сурагчид хамрагдах сонирхол маш их. Хүүхэд, залуус руу чиглэсэн ийм цогц сургалтыг зохион байгуулдаг дүүрэг тийм ч олон биш гэж миний хувьд боддог. Энэ бол бидний гар нийлэмжтэй ажиллагааны бодит жишээ юм" гэж хэлсэн. Мөн дүүргийнхээ сурагчдыг нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалтын төвийн сургалтад жил бүр хамруулдаг ажээ. Одоогийн байдлаар 3500 гаруй хүүхэд тус сургалтад хамрагдаж, гамшиг, ослын үед хэрхэн ажиллах талаар мэдлэгтэй болсон байна. Тэр бээр цааш нь "Орчин цагт хүүхдүүд хөдөлгөөний хомсдолд орж, суугаа байдалтай байх нь элбэг болсон. Үүнд Засаг даргын болон иргэнийхээ хувьд санаа зовниж явдаг. Тиймээс энэ мэт хөтөлбөр, сургалт, дугуйлангуудын үйл ажиллагааг дэмжиж, цэрэг-спортоор дамжуулан сурагчдын сэтгэл зүй, бие бялдын түвшинг дээшлүүлэхээр зорин ажиллаж, тодорхой үр дүнд хүрээд байна. Энэ бол манай дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цэргийн штаб, Онцгой байдал, Хил хамгаалах зэрэг олон байгууллага, хүмүүсийн чин сэтгэлийн оролцооны илрэл юм" гэв.

2017 онд хурандаа Л.Мөнхбат тус Цэргийн штабын даргаар томилогдоод төрийн батлан хамгаалах үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх үүднээс албаны өрөө, тасалгааг бүрэн засварлаж, бүх тавилга, бичгийн шүүгээг шинэчилжээ. Мөн хэргийн нөхцөлд хэрэглэгдэх



Хурандаа Л.МӨНХБАТ

асар, майхан, зөөврийн ширээ, сандал, эвхдэг ор, цахилгаан үүсгүүр, сургалтын материал хэрэгслийг худалдан авч, дайчилгааны бэлэн байдлын бэлтгэлжилтийн түвшинг нэмэгдүүлжээ. Үүний дүнд нийслэлийн ЗДТГ-ын удирдамжийн дагуу дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штабын үйл ажиллагаанд явуулсан хяналт шалгалтаар амжилт дүүрэн байж "Тэргүүний цэргийн штаб"-аар шалгарсан юм. Сүүлийн жилүүдэд хийж, хэрэгжүүлсэн ажлуудынхаа талаар хурандаа Л.Мөнхбат ярихдаа "Би дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабт томилогдсон даруйдаа хамт олныхоо ажиллах ая тухтай орчин нөхцөлийг дээшлүүлэхэд анхаарч, нэлээд ажлыг хэрэгжүүлсэн. Иргэд хамгийн түрүүнд биднээр дамжуулан цэргийн албаны тухай ойлголт авдаг учир цэргийн зарлан дуудах хуудас авсан иргэн, түүний ар гэр ая тухтай орчинд үйлчлүүлээд гарах нь чухал. Мөн Цэргийн штабын бэлэн байдлыг хангах үүднээс асар, майхан, халуун тогоо, ширээ, сандал гээд бүгдийг нь цогц байдлаар бүрдүүлэхийг зорьсон. Эдгээр болон бусад ажлыг маань нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас сайшааж, үйл ажиллагааныхаа үр дүнгээр "Бүрэн хангалттай" үнэлэгдэж,

нийслэлийн "Тэргүүний Цэргийн штаб"-аар тодорсон. Түүнчлэн мэдээллийн аюулгүй байдлын офицер, дэслэгч Б.Дэлгэрмаа Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын оны тэргүүний "Ажил мэргэжлийн аварга"-аар шалгарсан бол Баянгол дүүргийн "Шилдгийн шилдэг ажилтан"-аар миний бие шалгарснаас гадна дүүргийн ЗДТГ-ын "Шилдэг ажилтан"-аар шуурхай байдлын ахлагч, ахлах ахлагч Б.Дэмбэрэлбалжинням тодорлоо. Ер нь өнгөрсөн он манай Цэргийн штабт ээлтэй сайхан жил болж өнгөрсөн. Энэ бүх амжилтын цаана манай хамт олон, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Баянгол дүүргийн ЗДТГ-ын удирдлага, хамт олон зэрэг хэн бүхний гар нийлэмжтэй ажиллагаа, чин сэтгэл нөлөөлсөн" гэсэн юм.

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас 2020 оныг "Хууль тогтоомж, иргэн-цэргийн харилцааны жил" болгон зарлажээ. Үүнтэй уялдаад Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб хүүхэд, залуус руу чиглэсэн нэлээд ажлыг төлөвлөсөн байна. Энэ тухай хурандаа Л.Мөнхбат хэлэхдээ "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг Засгийн газраас баталсантай холбогдуулаад энэ жил төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран дүүргийнхээ Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнийг сурталчлахаас гадна эх орон, тусгаар тогтнолын үнэ цэнийн талаар яриа, таниулга хийх зэрэг олон ажлыг төлөвлөсөн. Мөн Улсын Их Хурлаас батлагдсан хуулиудын хүрээнд орон нутгийн хамгаалалтыг дүүргийн хэмжээнд зохион байгуулах, иргэдэд томилгоожуулах зэрэг хэд хэдэн томоохон ажил биднийг хүлээж байна. Манай улс шиг цөөн хүн амтай, өргөн уудам газар нутагтай оронд иргэд нь аливаа цагийн байдлын үед юу хийхээ мэддэг байх нь чухал. Энэ ажлын хүрээнд дайчилгааны бүх төрлийн баримт бичгүүдийг шинэчлэх, дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтыг чанаржуулах, орон нутгийн томилгоот бүлгүүдийн мэдээллийн санг бий болгохоор төлөвлөсөн. Ингэснээр тухайн дүүрэг, хорооны иргэн бүр аливаа гамшиг, осол, бусад цагийн байдлын үед хаана, юу хийхээ мэддэг болно. Энхийг дэмжих ажиллагаанд манай цэргийн алба хаагчдын бусад орны цэргүүдээс ялгардаг гол онцлог нь ямар ч үед хаана, юу хийхээ мэддэгт оршдог юм. Тухайлбал, би Афганистан, Сьерра Леон улсад үүрэг гүйцэтгэж байлаа. Тэр үед халдлага болоход гадаадын орны цэргүүд ширээн доогуур нуугдаж байхад монгол цэргүүд буугаа шүүрч аваад байлдааны ажиллагаанд шилждэг. Яг л үүнтэй агаар нэг орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгдэж үүрэг гүйцэтгэх иргэний үүргийг нь тодорхой болгож, бүр хамгаалах объектын нь хүртэл зааж өгөх ёстой юм. Ингэснээр иргэд ч өөрийн үүрэг, хариуцлагыг ухамсарлаж, хуулийн хэрэгжилтийг хангахад бодитой хувь нэмэр оруулах болно" гэлээ.

Цэргийн штабын сургалтын талаар төлөвлөлт, сургалтын офицер, дэд хурандаа Д.Эрдэнэбаяр хэлэхдээ "Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлийг олгох, аж ахуйн нэгж байгууллагуудад шалган туслах, албан тушаалтнуудын сургалтыг хороодын Засаг дарга нар, зохион байгуулагчид, цэргийн I болон II зэргийн бэлтгэл үүрэгтнүүдтэй явуулж байна. Тус сургалтуудыг чанартай, сайн зохион байгуулах нь биднээс гадна дүүргийн ЗДТГ-ын хэлтэс, албадын гар нийлэмжтэй ажиллагаанаас шууд хамаардаг. Манай дүүргийн албан хаагчдын хувьд бидний ажлыг маш сайн тусалж, дэмждэг гэдгийг хэлэхэд таатай байна. Өнгөрсөн онд үйл ажиллагаагаараа манлайлж, нийслэлийн "Тэргүүний Цэргийн штаб" болсон нь сургалтуудыг тухайн цаг үед нь чанартай зохион



Дэд хурандаа Д.ЭРДЭНЭБАЯР

байгуулсны үр дүн гэж бодож байна. Хороодын Засаг дарга нарын сургалтыг Дархан-Уул аймгийн ЗДТГ, Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 330 дугаар ангитай хамтран зохион байгуулсан. Тус сургалтаар Засаг дарга нар анги, байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдсанаас гадна Дархан хотын ЗДТГ, хороодын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалснаараа онцлог болсныг дурдахад таатай байна. Мөн тэмцээн уралдаанд залуус маань идэвхтэй оролцож ганзага дүүрэн ирцгээсэн. Тухайлбал, дүүргийн Ерөнхий боловсролын 19 сургуулиас шалгарсан баг нийслэлийн Засаг даргын нэрэмжит "Дөл" тэмцээнд оролцож, гуравдугаар байр эзэлсэн. Цэргийн дүйцүүлэх албыг хааж байгаа залуус нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан тэмцээнд оролцож медаль хүртсэн зэргийг нэрлэж болох юм" гэдгийг онцлов.

Үйл ажиллагаа, төлөвлөлт, зохион байгуулалт зэрэг бүхий л талаараа манлайлж яваа Цэргийн штабын ажил үйлсээс цухас дурдахад ийм байна. Тэдний хувьд 2020 он их ажлын жил бололтой. Улсын Их Хурлаас баталсан Орон нутгийн хамгаалалтын тухай хуультай уялдуулан төлөвлөлт, зохион байгуулалт, сургалт гээд олон ажил тэднийг хүлээж байна.

Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

(Түрүүч нь I нүүрт)

ДУГААРЫН СУРВАЛЖИЛГА

# ТЭД БУУХ ЭЗЭНТЭЙ, БУЦАХ ХАЯГТАЙ ОЛОН АЖЛЫН АРД ГАРНА

Их эзэн Богд Чингис хааны үеэс улбаатай морин цэргийн түүхийг энэ цаг дор үргэлжлүүлж яваа Зэвсэгт хүчний 232 дугаар ангиар зочиллоо. Өнгөрсөн жил түүхт 40 жилийн ойтойгоо золгосон тус анги биднийг өрнүүн их ажлын амжилттай угтлаа.

Тухайлбал, "Олон улсын цэргийн наадам 2019"-ийн хүрээнд Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан "Аравт" морин цэргийн уралдааны бэлтгэлийг хангах том ажлын ард гарцгаасан. Ингэхдээ зүүн гурван аймгаас 120 гаруй шилмэл агт морьдыг сонгосон. Мэдээж энд хүрээд зогсохгүй. Морьдоо сургаж, номхотгох ажлын тэргүүн фронтод тус ангийн цэрэг дайчид л давшигцаасан. Үүний үр дүнг ч тус тэмцээний зохион байгуулалт, ач холбогдлоос бид бэлхнээ харсан.

Энэ талаар тус ангийн захирагч, хурандаа Н.Мягмарцоож "Монгол



Хурандаа Н.МЯГМАРЦООЖ

Улсаа төлөөлөн оролцсон баг тамирчдын бүрэлдэхүүнд манай ангийн хоёр хугацаат цэргийн алба хаагч багтаж өндөр амжилт үзүүлсэн. Өөрөөр хэлбэл, хугацаат цэргийн алба хаагч олон улсын хэмжээний тэмцээнд оролцсон анхны тохиолдол" гэв. Тэрээр үргэлжлүүлэн "Төрийн их баяр наадамд Есөн хөлт цагаан тугийг залах шарга морьдынхоо бэлтгэлийг амжилттай хангасан. Манай анги нийслэл, аймгийн төвөөс алслагдсан сум, орон нутагт үйл ажиллагаагаа явуулдаг онцлогтой. Алслагдсан хэдий ч аймгийн удирдлага, бусад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагатай байнгын хамтын ажиллагаатай байсаар ирсэн. Хамтын ажиллагааны хүрээнд мэдээж төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгуулдаг уламжлалтай. Мөн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх сайжруулах хүрээнд сум, орон нутгийн нийтдээ 60 гаруй иргэнийг ажлын байраар хангаад байна.

Үндсэн хичээлээс гадуур сургалт бэлтгэлийг ангийн онцлогтойгоо уялдуулан байнгын бие бүрэлдэхүүнд морин байлдааны ажиллагаа, морь сургаж номхотгох чиглэлээр, харин хугацаат цэргийн алба хаагчдад сур нэгтгэж хэрхэн харьцах, сураар юу хийж болох гэх мэт монгол ахуй тал руу нь түлхүүт хандуулан явуулж байна" гэсэн юм. Түүний ярианд дурдагдалгүй өнгөрсөн олон ажлыг энд онцолж болох юм. Тухайлбал, Хэнтий аймгийн баруун таван сумдад байгаль, цаг уурын хүнд нөхцөл үүссэн үед ангийн зүгээс хүн хүч, туулах чадвар сайтай техник хэрэгслээр туслалцаа үзүүлж үүрэг гүйцэтгэдэг уламжлалтай. Энэ жилийн тухайд өөр нэмэлт үүрэг хүлээж, улсын сангаас малчдад хямдралтай үнээр хадлан, тэжээл тараах ажлын тэвэрлэлтийг тус ангийнхан хариуцаж шуурхай зохион байгуулжээ. Сумын сургууль, цэцэрлэгт алба хаагчдын хүүхдүүдийн дийлэнх нь сурч боловсордог тул сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг ч идэвхтэй дэмждэг аж. Соёл, урлагийн нэгдсэн арга хэмжээ гэдэг юу л байна, тэр бүхэнд ангийн зүгээс идэвхтэй оролцдог бас зохион байгуулдаг. Дэлгэрхаан сумын ЗДТГ-тай хамтраад жил бүр "Нууц товчоо"-гоо цэнгүүлэхэд морьт цэргээ оролцуулан Хэрлэн голынхоо эрэг орчмын дагуух хогийг нь цэвэрлэж хөвшсөн байна. Түүнчлэн байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх, сум, орон нутагтаа үлгэр жишээч хамт олон болох зорилгыг дор 500 гаруй

төрөл бүрийн модлог ургамал тарьсан нь ногоон орчныг бүрдүүлэхэд багагүй хувь нэмэр оруулсныг сум, орон нутгийн иргэд онцолж байв. Харин сум, орон нутгийн зүгээс ангийн бие бүрэлдэхүүний ая тухтай орчинд алба хаах нөхцөлийг нэн тэргүүнд тавьж, орон сууц болон буудлагын талбайн газар олгох асуудлыг нааштайгаар шийдэж өгчээ.

Захирагчийн ар тал, ахуй хангалт хариуцсан орлогч, хошууч Д.Цэнд хэлэхдээ "Налгар намартай золгосон даруйдаа



Хошууч Д.ЦЭНД

өөрсдийн хүн хүч, техник хэрэгслээр 240 тонн хадлан, тэжээл бэлтгэсэн. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Улаанбаатар цэргийн хүрээний ангиудын махны бэлтгэлийг хангадаг. Харин энэ удаад хямдралтай үнээр 97 тонн мах нийлүүлээд байна. Энэ нь ангийн түүхэнд үлдэх томоохон ажил. Өдий дайны мах бэлдэж ангиудад нийлүүлсэн ч энэ жилийн тооллогоор мал 1300-аар өссөн үзүүлэлт гарлаа. Зун, намрын отор сайн байснаас өвлийг өнтэй давлаа. Удахгүй хавартай золгох тул төл хүлээж авах их ажлын бэлтгэл ид явагдаж байна" гэлээ.

Сүүлийн үед тус ангид залуу албан хаагчид томилогдох нь ихэссэн бөгөөд нэн тэргүүнд тэднийг хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэх ёстой гэдэг дээр захирагчийн зөвлөл, ангийн удирдлагууд санал нэгджээ. Зүгээр ч нэг санал нэгдээд, өнгөрөлгүй орон байр, өрөө тасалгаа, компьютер, техник хэрэгслийн хангалтыг зохион байгуулахад ажил хэрэгчээр хандаж, ач холбогдол өгснөөр өөрсдийн мэдлийн "Хоёр загал" амралт, сувиллын газруудын байруудыг халаалтын системд холбох ажлыг хэдийнээ эхлүүлжээ. Ийнхүү алба



Аварга малчны болзол хангасан Д.Эрдэнэбатын гэр бүл

хаагчдынхаа амьдрах орчин нөхцөлийг нь сайжруулах хүрээнд үргэлж шинийг санаачилсаар байгааг тус ангийн талаарх өмнөх нийтлэлүүдээс илхнээ харж болохоор.

Үүнээс гадна алба хаагч, ажилтнуудынхаа хувь хүний хөгжил рүү чиглэсэн лекц, сургалтыг тогтмол явуулж байгаа аж. Энэ талаар ангийн удирдлагууд "Залуус маань хөгжих учиртай. Өөрийгөө мэргэжил ур, чадварын хувьд хөгжүүлэх шаардлагыг энэ эрин зуун хүссэн хүсээгүй нэхнэ. Цаашид алба хаагчид маань зөвхөн энд гэлтгүй хилийн чанадад ч үүрэг гүйцэтгэнэ. Үүрэг гүйцэтгээд ирсэн залуустаа ангийн захирагчийн зөвлөл, ахмад дайчдын зүгээс хэрхэн санхүүгийн сахилга баттай байх талаар зөвлөдөг" гээд тал бүрийн санаа тавьдаг гэдгээ илэрхийлсэн.

Дэлгэрхаан сум Зэвсэгт хүчний 232 дугаар ангиас 32 километрийн зайд орших "Уугийн ёл" хэмээх газар тус ангийн малчин Д.Эрдэнэбатынх өвөлждөг. Тэрээр удам дамжсан малчин бөгөөд түүний аав ч бас энэхүү ангийн хөгжил цэцэглэлтэд нэг насны амьдралаа зориулсан нэгэн. Тэднийд очих замд зээрийн сүрэгтэй хэдэнтээ таарав. Хүний

хөлөөс дайждаг энэ амьтан гирвэших нь бүү хэл машины дууг ч үл ажирна. Ингээд зорьсон газраа очиход гэрийн эзэн биднийг тосохоор гарч ирэв. Мэнд усаа мэдэлцээд гэрт ороход гэрийн эзэгтэй цай хоол зэхэхээр галаа нэмж суух зуур замд таарсан зээрийн сүргийн талаар хэсэг хуучилсан юм. Энэ замаар ойр ойрхон машин явдаг учраас зээрийн сүрэг бараг хүнд дасих нь холгүй болсон аж. Мөн аргалийн сүрэг ч энд нутагладаг гэнэ. Биднийг ийн ярилцаж суух зуур гаднаас хүүхдүүд нь шуугилдсаар орж ирэв. Д.Эрдэнэбатынх Э.Эрдэнэдагва, Э.Эрдэнэсамбуу, Э.Эрдэнэсүрэн, Э.Отгон-Эрдэнэ, Э.Отгон-Эрдэм гэсэн таван хүүхэдтэй. Э.Эрдэнэдагва, Э.Эрдэнэсамбуу нар Зэвсэгт хүчний ангиудад хугацаат цэргийн алба хаадаг бол Э.Эрдэнэсүрэн Хэнтий аймгийн Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 10 дугаар ангид сурдаг. Э.Отгон-Эрдэнэ Дэлгэрхаан сумын дунд сургуулийн тавдугаар ангийн сурагч. Гаднаас шаагилдсаар орж ирсэн гайхлууд бол Э.Эрдэнэсүрэн болон Э.Отгон-Эрдэнэ нар. Хоёр ах нь цэргийн албанд татагдсан учраас Э.Эрдэнэсүрэн охин гэрийнхээ ихэнх ажлыг нугалдаг болжээ. Дэлгэрхаан сумын сургуульд ахлах анги байдаггүй учраас тэрээр энэ жилээс эхлэн Хэнтий аймгийн Чингис хотын Ерөнхий боловсролын сургуульд суралцах болсон байна. Тиймээс амралтаараа аль болох аав, ээждээ тус дэм болохыг хичээдэг бөгөөд тэднийгээр гэр доторх ажилд бараг л оролцуулдаггүй гэнэ. Харин төрсөн цагаасаа малын ухаанаас холдоогүй Э.Отгон-Эрдэнэ хүү алсдаа аавынхаа голомтыг сахиж үлдэх, аав шигээ сайн малчин болох хүсэлтэй. Төв суурин газрын хүүхдүүд унтаж байхад харин Э.Отгон-Эрдэнэ өглөө эртлэн босож хонио хариулчхаад буцаж ирсэн даруйдаа биедээ таарсан ажил юу ч байсан зүхшээлгүй хийсээр үдийн нартай золгодог ажээ. Ер нь ч тэгээд малчны цаг наргүй ажилд эрт дадсан хүүхэд алсдаа зуд турханд нэг их зовоохгүй гэдэг дээ.

Д.Эрдэнэбат хүү Э.Отгон-

ажлын бүтээмжээрээ бусдыгаа манлайлан ангийн аварга малчны болзлыг хангасан тухай баяртай мэдээг дуулгалаа. Д.Эрдэнэбат баярт мөчөө хуваалцахдаа "Малчин хүн мянган мэргэжлийн эзэн гэсэн сайхан үг байдаг. Миний аав өрхөө татах гэж гарахдаа л тухайн өдөр тэнгэр ямар байхыг мэдчихдэг байж билээ. Цаашилбал, сар, улирал хоногоор нь шинжинэ. Бас малынхаа ааш аягийг ажиглана. Аяны шувуудын нүүдлийг хараад бас юм хэлчихдэг л байсан. Би ч бага сага зүйлд гаршсан ухаантай. Үүнийгээр үр хүүхдүүддээ өвлүүлнэ гэсэн бодол сэтгэлд уяатай явдаг даа" гэв. Үнэхээр ч сайн малчин түүний хэлсэн шиг цаг уурчаас гадна малын зоотехникч, уяач, малын удмын санг баяжуулагч гээд тоочоод байвал бий дээ бий. Малчны хотонд саатаж дуусаад биднийг буцах болоход Д.Эрдэнэбат, Д.Дагвасүрэн нар 232 дугаар ангид алба хааж буй хүү Д.Эрдэнэдагвадаа аварга малчин болсон баяртай мэдээг дуулгахыг бидэнтэй хамт явсан малын их эмч Б.Отгонжаргалаас хүсэв. Б.Отгонжаргал малчны хотонд зүгээр ч нэг ирээгүй бөгөөд газарчлахын сацуу малд үзлэг хийгээд буцаж буй нь энэ. Түүний хувьд тав дахь жилдээ

талаар "ЗДТГ-ын хамгийн ихээр дэмжиж ажилладаг байгууллага нь Зэвсэгт хүчний 232 дугаар анги. Цэргийнхэнтэйгээ хамтарч үйл ажиллагаа явуулахад их нөмөртэй, түшигтэй байдаг. Хамтраад иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх хүрээнд жил бүр төлөвлөгөөт ажлаас



Засаг дарга О.АНХБАТ

гадна олон зүйлийг санаачлан хийсээр ирсэн. 2020 онд Аварга тосон бүрд нуурыг хамгаалах, "Монголын нууц товчоо" цогцолборын барилгын ажлыг эхлүүлэх зэрэг олон чиглэлээр хамтарч хамтын ажиллагаагаа улам өргөжүүлнэ" гэлээ.

Чөлөөнд байгаа ахмад Д.Чойсүрэн өдгөө нас сүүдэр 75 хүрч байна. Тус ангид ар талын даргаар олон жил ажилласан тэрээр чөлөөндөө гарсан гэж хойш суулгүй одоо ч ангийн удирдлага, бие бүрэлдэхүүнтэй ойр байж тэдэнд зөвлөсөөр л явна. 1989 оны тэртээ Д.Чойсүрэн энэхүү ангийн түүхэнд эргэлт болохуйц томоохон алхмыг хийжээ.



Малын их эмч Б.ОТГОНЖАРГАЛ

тус ангийн малын нэгдсэн аж ахуйд ажиллаж байна. Түүнээс өмнө Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид 10 гаруй жил, улсад нийтдээ 38 жил ажилласан нөр их туршлагатай нэгэн ажээ. Гавьяаныхаа амралтад гарахаасаа урьтаж төрийн торгон сүрэгтэй энэхүү ангид ажиллах хүсэлдээ хөтлөгдөн Хэнтий нутгийг зорьжээ. Энд ажиллах хугацаандаа малын эмчээс гадна монгол ахуйгаасаа хөндийрсөн байлдагчдад мал маллах нарийн ширийн арга ухаанаас зааж зөвлөсөөр ирсэн ажээ. Сүүлийн жишээ гэхэд л өнгөрсөн намар халагдсан нэгэн байлдагч үнээ сааж, цагаан идээ боловсруулж сурсан бөгөөд тангаргийн баяраар юу сурснааэмээ, өвөөдөө харуулсан гэдгийг Б.Отгонжаргал онцолсон ба үргэлжлүүлэн "Манай хүн ч бас энэхүү ангид ажилладаг. Бид цэрэг армитай холбогдсон эдгээр жилд их зүйлийг ухаарч ойлгосон. Цэргийн алба бол бахархалтай алба. Тэр ч

Тодруулбал, төрийн мал сүргийг хорогдолгүй адгуулах, мөн ажилтан, алба хаагчдынхаа ажиллах орчин, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагыг үндэслэн тухайн үед ангийг Дэлгэрхаан сумын орон нутагт шилжүүлэхээр сум, орон нутгийн удирдлагуудтай тохиролцожээ. Ингэхдээ хоёр



Чөлөөнд байгаа ахмад Д.ЧОЙСҮРЭН

га газарт хоёр "вагончиг"-той ангийнхаа шавийг тавьж байсан бол өдгөө өргөжин дэвжээр Улаанбаатар цэргийн хүрээний ангиудын ар талын хангалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхээс гадна төрийн торгон сүргийн удам угшлыг сайжруулах, Их эзэн Богд Чингис



Сонголттой хоолны өдрөөр

үүднээс том хүүгээ цэргийн алба хаалгасан. Удалгүй бага хүү маань ч бас цэрэгт явна гэдэгт итгэлтэй" байна гэв.

Сурвалжлгын эхэнд тус ангийг сум, орон нутагт үйл ажиллагаа явуулдгаараа онцлогтой хэмээн дурдсан билээ. Тэгвэл Дэлгэрхаан сумын Засаг дарга О.Анхбат энэ

хааны морин цэргийн улбааг хадгалах гэдэг буух эзэн, буцах хаягтай олон ажлын ард гарч төр түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлсээр явна.

Хэнтий нутгаар зочлоход товчхондоо ийм буюу.

Ц.ЭНХ-ОРГИЛ

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

# ЧӨЛӨӨЛӨХ ДАЙН БА МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛ

Хүн төрөлхөнд хамгийн их аюул, гамшиг учруулсан Дэлхийн хоёрдугаар дайн тэртээ 1939 оны Халхын голын дайнаар эхэлсэн гэж сүүлийн үед судлаачид үзэж уг дайны түүхийг өөр өнцгөөс харах болсон. Тухайн үед Герман, Итали, Япон гурван улс холбоотон болж Халхын голын дайнаас өмнө дэлхий дахиныг хуваан эзлэх төлөвлөгөө боловсруулсан нь Халхын голын дайнд хүргэж улмаар Дэлхийн хоёрдугаар дайныг эхлүүлсэн юм. 1939 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр Халхын голын дайн дууссан дайны голомт Ази тивээс Европ руу шилжсэн нь түүхэн үнэн билээ. Харин 1945 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Герман улс бууж өгснөөр дайны голомт эргээд Ази тив рүү шилжин 1945 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр Дэлхийн хоёрдугаар дайн албан ёсоор дууссан юм.

Энэ өнцгөөс харвал Дэлхийн хоёрдугаар дайн монгол цэргээр эхлэн монгол цэргээр дууссан гэж үзэж болно.

Дэлхийн хоёрдугаар дайны хүнд хэцүү цаг үед Монголын ард түмэн 1936 онд 10 жилийн хугацаатай байгуулсан харилцан туслалцах гэрээний дагуу Зөвлөлтийн ард түмэнд туслан түүний итгэлт анд, үнэнч ар тал нь болж Алс дорнодын бүс нутгаар хэзээ мөдгүй өндөлзөхөөр эхэлж байсан Японы цэргийн эсрэг хамтын хүчээр зогсож байсан түүхийг хэн ч үгүйсгэж чадахгүй билээ. Японы эсрэг хийх энэхүү дайны учир шалтгаан, зорилт нь эртнээс улбаатай юм. Энэ дайн дан ганц Японы эсрэг дайн бус харин Монголын ард түмний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалтай салшгүй холбоотой учир Халхын голын дайнаас ч илүү ач холбогдолтой юм. Бид Халхын голын дайнаар тусгаар улс болох замаа сонгосон бол Чөлөөлөх дайнаар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулж чадсан билээ.

БНМАУ-ын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх эсэх асуудал 1940-өөд оны эхнээс олон улсын тавцанд албан ёсоор яригдаж ирсэн юм. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнгээр бид тусгаар тогтнолоо зарласан ч 1915 оны Хиагтын гурван улсын гэрээгээр өөртөө засах автономит эрхтэй болж статусаа алдсан. 1919 онд Хятадын генерал Сю Шү Жан Монголын автономитыг хүчээр устган Хятадын нэг муж болгосон бол 1921 оны 2 дугаар сард Барон Унгерн Нийслэл хүрээг чөлөөлөн дахин өөрөө өөртөө тусгаар тогтнолоо зарласан. Гэвч 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалаар тусгаар улс боллоо хэмээн монголчууд бодож байсан ч үнэн хэрэгтээ ЗХУ 1924 оны Караханы гэрээгээр Монголыг Хятадын салшгүй нэг хэсэг гэж далдуур хүлээн зөвшөөрсөн. Тэр ч бүү хэл Японы байгуулсан Манж улсыг (Манж-Го) дэлхийн 20 гаруй улс тусгаар улс хэмээн хүлээн зөвшөөрсөн байхад Монголыг нэг нь ч улс гэж үздэггүй тийм ээдрээтэй, бидний хувь тавилан хаашаа ч эргэж болзошгүй цаг үе байсан юм.

Монгол Улс 1930-аад оны эхнээс тусгаар тогтнолын асуудлаа хүчтэй гарган ирж, хятадуудаар хүлээн зөвшөөрүүлэх гэж оролдож ирсэн ч зайлшгүй их гүрнүүдийн дэмжлэг хэрэгтэй байсан юм. Тийм ч учраас олон улсын тавцанд өөрсдийгөө таниулах алхам хийж ирсэн. Энэ нь дараах хэд хэдэн үе шатыг туулсан. Үүнд:

## Нэгдүгээрт, Каирын бага хурал

1943 оны 11 дүгээр сарын 22-26-ны өдрүүдэд Египетийн хотноо болсон холбоотон гүрнүүдийн бага хурлын үеэр АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт, Хятадын удирдагч Чан Кайши нар хоёр удаа уулзахад, Ф.Рузвельт дайны дараа Америк-Хятадын цэргийн холбоог байгуулж, Хятад-Зөвлөлтийн хилийн дагуу АНУ-ын цэргийн баазуудыг байгуулах саналыг тавьсан бөгөөд Чан Кайши ихэд олзуурхан хүлээн авч, хариуд нь Монголыг Зөвлөлтийн нөлөөнөөс гаргаж Хятадад нэгтгэж өгөх, энэ талаар ЗХУ-д шахалт үзүүлэхийг хүссэн байдаг. Гэвч АНУ-ын ерөнхийлөгч уг асуудалд анхааралтай хандаж, асуудлыг судлан үзэхийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан байдаг. Монголын асуудлаар бодлогогүй алхам хийвэл ЗХУ-ын бодлого хаашаа ч эргэж мэднэ. Нөгөө талаар холбоотон улсуудын дунд асар том үл ойлголцол гарч мэдэхээр байсан тул маш нухацтай судлан хандахаар болжээ. Ингээд АНУ-ын дэд ерөнхийлөгч Генри Уоллес 1944 оны 7 дугаар



1945 оны 7 дугаар сарын 4-ний өдөр. Москва хот

сарын 2-4-ний өдөр Монгол Улсад анх удаагаа албан ёсны айлчлал хийж Монголын удирдагч, маршал Х.Чойбалсан мөн Зөвлөлтийн зарим төлөөлөгч нартай уулзан ерөнхийлөгч Ф.Рузвельтэд өгсөн илтгэлдээ "Монголчууд тусгаар тогтнох бүрэн эрмэлзэлтэй, өөрсдийгөө одоо ч гэсэн тусгаар улс гэж бодож явдаг, энд Зөвлөлтийн нөлөө хүчтэй тогтсон" гэх зэргээр дурдсан нь ерөнхийлөгч Ф.Рузвельтын Монголын талаарх цаашдын бодлогод хүчтэй нөлөө үзүүлсэн нь түүний гаргасан дараа дараагийн шийдвэрээс харагддаг.

## Хоёрдугаарт, Ялтын бага хурал

Холбоотон гүрнүүд хувь заяа нь нэгэнт тодорхой болсон Германыг буулгаж авсны дараах Европын хувь заяаны асуудлаар Крымын хойгийн Ялта хотод 1945 оны 2 дугаар сарын 4-11-ний өдөр бага хурал зохион байгуулсан юм. Хуралд ЗХУ-ын удирдагч И.Сталин, АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт, Их Британийн ерөнхий сайд У.Черчилль нар өөр өөрсдийн гол хэргийн модоо барьсаар оролцсон юм. Тухайлбал, АНУ-ын хувьд НҮБ-ыг байгуулах, Японы эсрэг дайнд ЗХУ-ыг татан оролцуулах, Их Британи улс хүчний тэнцвэрийг хадгалан үлдэх, ЗХУ чөлөөлсөн газар нутагтаа өөрийн нөлөөллийг тогтоох гэх мэт байжээ. Хурлын үндсэн агуулга нь дараах гол хэсэг дээр төвлөрч байжээ. Үүнд:

Ялтын бага хурлаар зургаан зүйлийн тохиролцоонд хүрсэн. Үүнд:

1.НҮБ-ыг байгуулах, Сан Францискогийн бага хуралд ЗХУ оролцох, мөн нэмж Беларусь, Украйны гишүүнчлэлийн эрхийг олж авах;

2.Польшийн зүүн хилийг Керзоны шугамаар тогтоох, 1939 оны нууц протоколоор олж авсан газар нутгаа ЗХУ өөрийн мэдэлд үлдээхээр болсон. Английн лорд Керзоны нэрээр хоёр улсын энэхүү хилийн маргаантай бүсийг нэрлэжээ;

3.Герман бууж өгсний дараа ЗХУ Японд дайн зарлах. Гэхдээ Сахалины өмнөд хэсэг, Курилийн арлуудыг мэдэлдээ авч, Ф.Рузвельт Чан Кайшид нөлөөлснөөр Монголын тусгаар тогтнолыг Дундад иргэн улсаар хүлээн зөвшөөрүүлэх, Манжуур дахь Зөвлөлтийн нөлөөг хүлээн зөвшөөрүүлэх, мөн АНУ, Англи хоёр Монголын статус-квог хүлээн зөвшөөрөх;

4.Югославт байгуулагдсан Иосиф Титогийн коммунист Засгийн газрыг хүлээн зөвшөөрөх;

5.Тэнхлэгийн гүрнүүдээс хамааралтай байсан улсуудын улс төр болон эдийн засагт холбоотон гүрнүүд туслалаар болж, энэ дагуу ЗХУ Дорнод Европ болон Балканы орнуудад туслалх эрхтэй болсон;

6.Герман дайны төлбөрт 20 тэрбум долларыг 10 жилийн хугацаатай төлөх. Дайны дараа Германд холбоотон гүрнүүдийн хяналтыг тогтоох, зэвсгийг бүрэн хураах, цэрэгжүүлэхгүй байх, ирээдүйд дахин өндийлгөхгүйн тулд Германыг хэсэгчлэн хуваах тухай.

Талууд өөр өөрсдийн тавьсан нөхцөлүүдийг ерөнхийд нь хүлээн зөвшөөрч буйгаа илэрхийлэн гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Ялангуяа Монголын тусгаар тогтнолыг Чан Кайшигаар хүлээн зөвшөөрүүлэх үүргийг АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт хүлээсэн нь тун чухал шийдвэр байсан юм. Тэгээд ч ЗХУ, АНУ, Их Британийн удирдагчид Японы эсрэг дайнд ЗХУ оролцох нөхцөлийн тухай хэлэлцээрийн эхэнд "Гадаад Монголын (БНМАУ) статус-квог хэвээр хадгална" гэж заасан нь Монголын тусгаар тогтнолыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэхэд чухал түлхэц болсон юм.

Ялтын бага хурлын үр дүнг Хятадууд 3 дугаар сараас мэдэж эхлэн хэл ам хийж эхэлсэн байдаг. Өөрсдийг нь оролцуулагчид Хятадын

хувь заяаг шийдсэнд бухимдсан Чан Кайши өөрийн төлөөлөгчдөө 1945 оны 6 дугаар сард Москвад илгээн Монголын "статус-кво"-нь талаар ярилцжээ. ЗХУ-ын удирдагч И.Сталин Монголын тусгаар тогтнолыг үгүйсгэх гэсэн Хятадын талын аливаа оролдлогыг тухай бүрт нь хатуугаар няцааж байсан юм. "Гадаад Монголыг одоо байгаагаар нь хүлээн авахгүй бол Өвөр Монголыг нэгдэж дийлдэхгүй болно, Гадаад Монгол бол ЗХУ-ын хувьд ч тэр, Хятадын хувьд ч тэр буфер улс байх ёстой, хэрэв Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй бол Японы эсрэг дайнд орохгүй, мөн Хятадын коммунистуудад зэр зэвсгээр тусална" гэх зэргээр хариулж няцааж байсан юм.

Хятадын гадаад хэргийн сайд нь И.Сталины болзлыг хүлээн зөвшөөрч чадахгүйгээ илэрхийлэн Москвад байхдаа огцорч, орных нь шинэ сайд Чуньцинээс Москвад очин хэлэлцээг дуусгасан юм. ЗХУ-ын удирдагч И.Сталин энэ үед улс төрийн чадварлаг тоглолт хийж БНМАУ-ын удирдагч, маршал Х.Чойбалсанг 1945 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Москвад урин анх удаагаа тусгаар улсын төрийн тэргүүний хувиар хүндэт харуултай төрийн дээд хэмжээнд хүлээн авч угтжээ.

Энэ нь Хятадын төлөөлөгчдөд БНМАУ бол тусгаар тогтносон улс нөгөө талаар ЗХУ Монголын талаарх өөрийн байр сууриа өөрчлөхгүй гэсэн санаагаа Хятадын талд өгсөн үйлдэл байсан юм. Айлчлалын үед Х.Чойбалсан Японы эсрэг дайнд холбоотны хувьд ЗХУ-тай хамтран БНМАУ-ыг оролцуулах талаар тохиролцож чадсан байна. Энэ нь нэг талаар холбоотон улсын хувьд ч нөгөө талаар тусгаар тогтносон бүрэн эрхт улс, мөн өөрийн гэсэн бие даасан цэрэг армитай улс гэдгээ Хятадын талд харуулж дэлхийн улс орнуудаар тусгаар улс гэдгээ баталгаажуулахад оршиж байсан юм.

Нөхцөл байдалтай нүүр тулан бууж өгсөн Хятадын тал ЗХУ болон АНУ-ын шахалтад орж 1945 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Зөвлөлт Холбоот Улс, Дундад иргэн улс хооронд Найрамдал, холбооны тухай гэрээ байгуулан гарын үсэг зурсан. Гэрээг 30 жилийн хугацаатай байгуулсан бөгөөд заалтад нь "БНМАУ-ын тусгаар тогтнолыг Дундад иргэн улс хүлээн зөвшөөрнө" хэмээн заажээ. Дээрх заалтын дагуу Хятадын тал Гадаад Монголын хүн амаас санал асуулга явуулж тэр үр дүнгээр Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөр болсон билээ. Ийнхүү монголчуудын тусгаар улс болох зам нь нээлттэй болсон төдийгүй энэ нь ганцхан цаг хугацааны л асуудал болсон юм. Юуны өмнө БНМАУ нь Японы эсрэг дайнд оролцох нь чухал байсан билээ. Энэхүү дайныг ялалтаар дуусган даян дэлхийд ялагч орны нэг болох нь улс төрийн өндөр ач холбогдолтой байжээ.

Судлаачид БНМАУ-ын Японы эсрэг дайнд оролцох болсон дараах шалтгаануудыг санал нэгтэй хүлээн зөвшөөрдөг. Үүнд:

1.Зүүн хойд Ази дахь Японы Квантуны армийг бут цохихын тулд ЗХУ нь стратегийн гурван чиглэл сонгож авсны нэг нь БНМАУ-ын нутаг буюу Тамсагбулагийн районоос өгөх хүчтэй цохилт байжээ. БНМАУ-ын стратегийн давуу байрлал нь Японы эсрэг дайнд Монголыг татан оролцуулах нэг нөхцөл нь болж өгсөн байна.

2.БНМАУ нь 1913 оны таван замын байлдааны үеийн нэгэн адил дүүдэ угсаа нэгтэй Өвөр Монгол ахан үндэс чөлөөлөн нэгдсэн хүчирхэг Монгол Улсыг байгуулахаар зорьж байсанд оршино. 1911 онд Богд хаант Монгол Улс байгуулагдаж тусгаар тогтнолоо зарлан тунхаглаад

1691 оноос хойш Манж Чин гүрний нөлөөнд байсан Өвөр Монгол ахан дүүсээ чөлөөлөхөөр болж бие даан 1913 онд таван замын байлдааныг эхлүүлэн амжилттай байлдаж байсан ч их гүрнүүдийн шахалтаар цэргээ аргагүйн эрхэнд татаж байсан түүхтэй. Тэрхүү түүх мөн л олон жилийн дараа давтагдах хувь зохиолтой байжээ. Өвөр Монгол ахан дүүс ч гэсэн БНМАУ-ын дайнд оролцох чимээгээр ихэд итгэл найдвар тавин хүлээж, нэгдэх хүсэлтээ янз бүрийн хэлбэрээр илэрхийлэх болсон юм. Тийм ч учраас энэхүү аятай цаг үед БНМАУ дайнд оролцох нь туйлын чин хүсэл нь болсон юм.

3.БНМАУ, ЗХУ-ын хооронд 1936 онд байгуулсан харилцан туслалцах протоколын дагуу өөрийн үүргээ үнэнчээр биелүүлэх зорилгын үүднээс юм. Хоёр тал гэрээний үүргээ харилцан үнэнчээр биелүүлж ирсэн түүхтэй. 1939 оны Халхын голын дайн болон Аугаа их Эх орны дайны хүнд жилүүдэд БНМАУ нь Зөвлөлтийн ард түмэн, цэрэг дайчдад чин сэтгэлийн халуун тусламж, дэмжлэгийг үзүүлэн зургаан удаагийн бэлгийн цуваа, 53 танк бүхий "Хувьсгалт Монгол" танкийн бригад, 12 нисэх онгоц бүхий "Монгол ард" нисэх эскадриль, мөн 500 мянга гаруй агт морь бэлэглэх буюу худалдах, олон тооны алт, үнэт эдлэл зэргээр харамгүй туслан дэмжиж байсан билээ. Өөрөөр хэлбэл, фашист Германы эсрэг явуулж байсан ЗХУ-ын дайныг дэмжиж байсан шигээ Японы эсрэг дайныг мөн дэмжиж байжээ.

4.Нийтийн дайсныг түргэнээр бүрмөсөн цохиж устгах гэсэн ардчилсан улсууд ба нэгдсэн үндэстний үйлсэд өөрийн тус нэмрийг оруулахын тулд дайнд орох болсноо илэрхийлсний хамт энэхүү тэмцэлд бүх "монгол овогтон... нэгэн зэргээр хөдлөн босооцоо"-ыг уриалсанд оршиж байжээ. Зүүн хойд Азийн бүс нутагт өрнөж байсан дайныг дуусган бүс нутагтаа энх тайван, амар амгаланг тогтоох нь БНМАУ-ын хувьд дэлхий дахины өмнө хүлээсэн журамт үүрэг, эрх ашигт нийцэж байсан юм.



1945 оны 2 дугаар сарын 4-11-ний өдөр. Ялтын бага хуралд оролцогчид

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид, Ардын сайд нарын Зөвлөлийн гишүүдийн 1945 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хамтарсан онц хурлаас БНМАУ-аас Японд дайн зарлах тухай тунхаг бичгийг батлан гаргасан байна. Энэхүү тунхаг бичгийн дагуу БНМАУ-ын 21,000 гаруй цэрэг дайнд оролцож орны хувьд дуусгасан билээ. БНМАУ Японы эсрэг дайнд оролцсон нь ХХ зууны Монголын түүхэнд томоохон байр суурь эзлэх үйл явдал мөн юм.

Чөлөөлөх дайны үр дүн, ач холбогдол юу байсан юм бэ? Уг дайны цэрэг, улс төрийн ач холбогдлыг дараах хэдхэн зүйлээр тодорхойлж болно.

1.Чөлөөлөх дайнд БНМАУ оролцоноороо өөрийн нэр, хүнд байр суурийг тодорхойлон олон улсын тавцанд тусгаар улс гэж хүлээн зөвшөөрүүлэх алхмаа тавьсан.

2.ЗХУ-тай 1936 онд байгуулсан харилцан туслалцах протоколоор хүлээсэн үүргээ үнэнчээр биелүүлэн даян дэлхийд энх тайван байдлыг тогтооход өөрийн үүргээ амжилттай биелүүлсэн.

3.Уг дайны үр дүнд 1945 оны 10 дугаар сард Монгол орон даяар тусгаар тогтнолын төлөөх бүх нийтийн санал асуулга болж бүгд тусгаар тогтнолын төлөө 100% санал өгсөн юм. Мөн БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1946 оны 2 дугаар сарын 27-ны өдөр Нөхөрлөл ба харилцан туслалцах тухай гэрээнд гарын үсэг зуржээ. Ийнхүү БНМАУ-ын тусгаар тогтнолыг анх удаа Дундад иргэн улсаар хүлээн зөвшөөрүүлж, хөнд их хөрш ЗХУ-тай анх удаа Нөхөрлөл, харилцан туслалцах гэрээ байгуулсан нь Чөлөөлөх дайны үр дүнтэй холбоотой юм.

4.Хамгийн гол нь АНУ, Англи зэрэг холбоотон гүрнүүдээр БНМАУ-ын статус-квог баталгаажуулсан явдал энэ дайнд Монгол Улс, түүний Зэвсэгт хүчин оролцсоны улс төрийн ач холбогдол, гол үр дүн оршино.

5.Хэдийгээр Чөлөөлөх дайны үед Өвөр Монгол ахан дүүсээ нэгтгэж чадаагүй ч олон жил тусгаарлагдаж байсан ах дүү нартаа итгэлийн оч бадрааж мөн олон тооны өрх айл хүмүүс нүүдэллэн ирсэн нь Монголын эдийн засаг, нийгэмд тодорхой нөлөө үзүүлсэн юм.

6.1939 оны Халхын голын дайны үеийн МАХЦ-ээс 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон цэргүүд эрс ялгагдаж байлаа. Тэр үеэс байлдах чадвар, даргалах бүрэлдэхүүн, зэр зэвсэг гээд бүхий л талаар дадлагажиж суралцсан үр чадвар өндөр орчин цагийн Зэвсэгт хүчинтэй болж цааш цаашдын Зэвсэгт хүчний хөгжилд томоохон байр суурийг авчирсан билээ.

7.Чөлөөлөх дайн бол Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөл болсон. 1939 оны Халхын голын дайнаар эхэлсэн дэлхийн их дайныг монгол цэрэг амжилттай төгсгөж чадсан нь олон улсын харилцаанд томоохон өөрчлөлтийг бий болгож Ази тивд дайны голомтыг унтрааж энх тайван байдлыг тогтоох, Дорно дахины улс түмний эрх чөлөөгөө олж авах тэмцэлд хүчтэй дэмжлэг үзүүлсэн юм.

Эдүгээгээс 75 жилийн тэртээ болсон Чөлөөлөх дайны түүхийг бид хэтэрхий сайн мэддэг хэрнээ хэтэрхий сайн мэдэн будилдаг болжээ. Халхын голын дайны ялалтын 80 жилийн ойн хүрэн дэх нийгмийг талцуулсан, төөрөгдүүлсэн шинэ цагийн түүхчид өнөөх сурсан зангаараа Чөлөөлөх дайны 75 жилийн ойн ач холбогдол, МАХЦ-ийн гүйцэтгэсэн үүргийг үгүйсгэж, өмчлөх, ач холбогдлыг нь бууруулах гэж оролдож байна. Чөлөөлөх дайнд монголчууд бараг оролцоогүй, байлдаагүй, арын албанд явж байсан, өрөөсөө Японы цэргүүд цагаан туг өргөн бууж өгөөд байсан мэтээр улиглан бичих нь элбэг болж. Нөгөө талаар нийгмийн сүлжээнд нэр нүүрээ нуусан хэсэг бүлэг этгээдүүд түүхийг үгүйсгэн хүсэж, бах таваа



хангах нь олонтоо тохиолдоно.

Аливаа түүхэнд алдаа, оноо байдаг. Түүнийг эргэн дурсаж, судлан нягтлах нь түүхч, судлаачдын үүрэг билээ. Тийм ч учраас Чөлөөлөх дайны түүхийн судалгаа цэргийн түүхчдийн хувьд нэн тэргүүний зорилт бөгөөд энэ хүрээнд БХЭШХ-ийн нэрт түүхч Д.Гомбосүрэнгийн нэрэмжит Цэргийн түүх судлалын төв ОХУ-ын Шинжлэх ухааны академийн Сибирийн салбарын Монгол, Төвөд, Будда судлалын хүрээлэнтэй хамтран "Монгол цэрэг дэлхийн 2 дугаар дайнд" хэмээх хоёр улсын хамтарсан төслийг 2018 онд гүйцэтгэж, Шинжлэх ухаан, технологийн санд хүлээлгэн өгсөн. Энэ бол хамгийн сүүлийн үеийн бодитой, 1990 оноос хойш хийгдээгүй томоохон судалгааны ажил яах аргагүй мөн.

Эцэст нь дүгнэхэд Чөлөөлөх дайны үр дүнгээр Монгол Улс тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа олж авсан нь түүхэн үнэн. Монгол цэрэг дайснаа дарж даян дэлхийд энхийг сахиулах үүргээ нэр төртэй биелүүлсэн нь няцаашгүй үнэн. Тиймээс жил бүрийн 9 дүгээр сарын 2-ны өдөр тусгаар тогтнол, эрх чөлөөг ямар үнээр олдсоныг ямагт санан дурсаж, эх орныхоо төлөө алтан амь, бүлээн цусаа зориулсан баатарлаг цэрэг эрсээрээ бахархан амьдрах ёстой. Энэ ч утгаараа Чөлөөлөх дайны ялалтын ой бол монгол хүн бүрийн сэтгэл догдлон хүлээдэг тийм л баярын өдөр байх ёстой гэж боддог. Аугаа Монголын үе үеийн суу заль ихт удирдагчид, жанжид, баатарлаг цэрэг эрсдээ мэхийн хүндэтгэл үзүүлж байна.

**БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор, хошууч Т.СҮХБААТАР**

## ХИЛИЙН ЧАНАДААС

Эрхэм уншигч танд БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний IX ээлжийн мотобуудлагын батальоны Цэргийн цагдаагийн бүлгийн зохицуулагч, дэслэгч Х.ХАШ-ЭРДЭНЭ (БХЯ-ны “Алдар” спорт хорооны дасгалжуулагч, ОУХМ, хошууч)-тэй хийсэн ярилцлагыг хүргэж байна.

**Эхлээд Таныг уншигчдадаа товч танилцуулъя ...**

-Би Орхон аймгийн Баян-Өндөр сум буюу Эрдэнэт хотын уугуул. Дөрвөн хүүтэй айлын хоёр дахь хүү. Орхон аймгийн Ерөнхий боловсролын IV сургуулийг 2001 онд, МУБИС-ийн Биеийн тамирын дээд сургуулийг багш, дасгалжуулагч мэргэжлээр 2006 онд төгссөн. Оюутан байх хугацаандаа “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн

алт, нэг мөнгөн медаль хүртлээ. Мөн “Алдар” спорт хорооны баг, тамирчдыг хариуцан бэлтгэж оролцуулсан маань амжилт дээр амжилт нэмж тэд маань багийн дүнгээр нэгдүгээр байрт шалгарсан. Ингэж л Цогоо багшид тоогдож, итгэлийг нь хүлээж, дэмжлэгийг нь хүртэж 2008 онд офицер болоод Зэвсэгт хүчний 032 дугаар ангид Цэргийн цагдаагийн ротын зохицуулагч, 2012 онд Зэвсэгт

зөвхөн өөртөө төвлөрч, багшийн заавар, зөвлөгөөг дагаж бэлтгэл сургуулилтаа базаах, хэн нэгэн тамирчныг мэдэрч, түүнийг дасгалжуулан чиглүүлэх өөр. Товчхондоо тамирчин бэлтгэнэ гэдэг амаргүй. Гэсэн хэдий ч миний хувьд 2012 онд тамирчин уу, эсвэл дасгалжуулагч уу гэдэг сонголттой тулж, тамирчны хувьд “карьер” маань дуусаагүй байсан ч өнөөдрийн сонголттой хийсэн.

## СПОРТ “ХӨӨСӨН” ХҮН ЭРҮҮЛ МЭНДДЭЭ АСАР ИХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙДЭГ



нийгэмлэгийн “Замчин” спорт хорооны тамирчин байсан. Спортын гараа маань 1998 оноос буюу зургаа дугаар ангийн сурагч байхаас эхлэлтэй. Миний анхны багш ОУХМ Г.Ганбаатар гэж хүн бий. Багш маань тухайн үед Орхон аймгийн спорт хорооны дасгалжуулагчаар ажиллаж байлаа. Спорт тэр тусмаа цанын спортын “А” үсгийг анхлан зааж, чиглүүлэн өдий зэрэгт хүргэсэн багшдаа ямагт баярлаж явдаг. Мөн “Замчин” спорт хороонд байхдаа цанын спортын ОУХМ Л.Дорж багшийн удирдлагад бэлтгэл сургуулилтаа базаадаг байлаа.

**Зэвсэгт хүчин хэмээх их айлд хэзээ, хэрхэн бүл нэмсэн юм бэ?**

-2006 онд “Замчин” спорт хороонд байхдаа телевизийн нэгэн шоу нэвтрүүлэгт оролцлоо. Яах вэ, залуу хүний хувьд өөрийгөө сорилд үзье гэсэн сонинч зандаа хөтлөгдөөд тэр шүү дээ. Гэтэл удирдлагууд маань тэрхүү нэвтрүүлэгт орсныг мэдээд халчихдаг юм байна. Спорт гэдэг өөрөө их хатуу шалгууртай бас их зарчимтай учраас тийм шийдвэр гаргасан хэрэг. Энэ хүн спортын карьераа орхиж байгаа юм байна, энэ хүнээс амжилт гарахгүй гэж ч ойлгоосон юм билээ. Харин миний хувьд спортоо орхисон хэрэг огт биш байв. Тэгээд л шарандаа “Алдар” спорт хороонд очиж Д.Цог-Эрдэнэ багштай уулзлаа. Тухайн үед Бүх ард түмний өвлийн спартакиад /2008 оны/ дөхчихсөн байж таарав. Энэ наадмаас нэг тамирчин дөрвөн медаль хүртэх боломжтой байдаг л даа. Тийм болохоор Цогоо багшид “Бүх ард түмний өвлийн их наадмаас хамгийн дээд амжилт буюу дөрвөн медаль авна” гэсэн амлалт өгч, багш маань дэмжсэнээр 2007 онд Зэвсэгт хүчний 065 дугаар ангид томилогдон Зэвсэгт хүчнээр овоглоход болсон юм. Ингээд л бэлтгэл сургуулилтаа шамдаж, 2008 оны Бүх ард түмний өвлийн их наадмаас гүйлтийн цанын төрлөөр гурван

хүчний 089 дүгээр ангийн Биеийн тамирын дарга, 2012 оноос өдгөөг хүртэл “Алдар” спорт хороонд дасгалжуулагчаар ажиллаж байна. Хэдийгээр аль нэг ангид ажилладаг байсан ч тамирчныхаа хувьд 2008 оноос “Алдар”-аар овоглогдсон байна.

**Амжилтын гараа, хүч сорьсны томоохон тэмцээнүүдийнхээ тухай товч дурдахгүй юу?**

-1998 онд спортын гараагаа эхлүүлсэн гэж дээр ярьсан шүү дээ. Тэр цагаас эхлээд л Орхон аймагт зохиогддог төдийгүй улсын чанартай тэмцээнүүд цаашлаад олон улсын чанартай цөөнгүй тэмцээнд оролцож чамлахааргүй амжилт үзүүлсэн. Энэ ч утгаараа 2002-2012 онд улсын шигшээ багт багтсан маань надад хамгийн том шагнал бас асар их хариуцлага байсан. Олон улсын чанартай томоохон тэмцээнээс дурдвал 2006 онд Италийн Торини, 2010 онд Канадын Ванкувер хотноо болсон өвлийн олимпод оролцсон, мөн 2018 оны өвлийн олимпод баг, тамирчдаа бэлтгэж оролцуулсан. Эдгээр олимпод 100 гаруй улс орны баг, тамирчид оролцсон бөгөөд манайхан амжилтаараа 82 дугаар байрт жагсаж байлаа. Хэдийгээр энэ тоон үзүүлэлт чамлалттай харагдах боловч цагаан олимпын эрх авна гэдэг өөрөө асар том хариуцлага, хүч, хөдөлмөр байдгийг спорт сонирхогчид андахгүй биз. Ялангуяа манай улсын хувьд бэлтгэл базаах орчин нөхцөл, техник хэрэгслийн хангалт, боломжийн тухайд асуудалтай. Гэсэн хэдий ч бид аль болох бүхий л боломжоо дайчлан эх орныхоо нэрийг дэлхийн тавцанд гаргахыг хичээдэг.

**Тамирчин Хашаа 2012 оноос дасгалжуулагч Хашаа болсныг мэдэх юм байна. Дасгалжуулагч, тамирчин хоёрын хооронд асар их ялгаа бий байх ...**

-Ялгаатай байлгүй яах вэ. Өөрөө өөрийгөө мэдэрч,

**Гүйлтийн цанын спортын онцлогийн тухайд тодруулахгүй юу?**

-Тэсвэр, тэнцвэр, хүч, хурдыг шаарддагаас гадна дөрвөн мөч болон хамгийн идэвхгүй гэгддэг хүзүүний булчинг давхар ажиллуулдаг, биеийг өв тэгш хөгжүүлдэг спорт.

**Ер нь спортын үнэ цэн юунд оршдог гэж тамирчин хүний хувьд та үздэг вэ?**

-Тамирчин хүний хувьд санасандаа хүртэл амжилт үзүүлчээд зогсож байх тэр агшин, амжилтын төлөө гаргасан ганцхан дусал хөлс ч үнэ цэнтэй. Түүнчлэн спорт “хөөсөн” хүн эрүүл мэнддээ асар их хөрөнгө оруулалт хийдэг, эрүүл энх байна гэдэг юутай ч зүйрлэшгүй үнэ цэн биш гэж үү. Мөн хувь хүнийхээ хувьд тэсвэр хатуужил, төлөвлөөс эхлээд эерэг нөлөө хэмжээлшгүй.

**Гэр бүлийн тань тухайд тодотгоё ...**

-Миний хань ЦЕГ-ын харьяа Хамгаалалтын газрын хяналт, шалгалтын офицер, дэслэгч Х.Эрдэнэчимэг гэж бүсгүй бий. Бид гурван хүүтэй. Том хүү маань есдүгээр ангийн сурагч, дунд хүү дөрвөн настай, бага хүү 10 сартай. Эхнэр маань 2013 онд буюу энэхүү ажиллагааны хоёрдугаар ээлжийн цэргийн багт үүрэг гүйцэтгэсэн. Миний хувьд 2010 онд Чад улсад, 2012 онд мөн энэ ажиллагааны нэгдүгээр ээлжээр үүрэг гүйцэтгэсэн.

**Уламжлалт Сар шинийн баяр тун удахгүй тохиох гэж байна. Энэхүү баяр танай гэр бүлийн хувьд хэр үнэ цэнтэй баяр вэ?**

-Өвөг дээдсээс өвлөгдөж ирсэн үндэсний уламжлалт баяртаа нэлээд ач холбогдол өгч, ёс заншлаа эрхэмлэн хүндэтгэж тэмдэглэдэг. Мэдээж Шинийн нэгний өглөө эртлэн босож, гэрийн эзний хувьд мөрөө гаргадаг. Дараа нь гэр бүлээрээ шинэ цайгаа ууж, хүүхдүүдтэйгээ золгоод аав, ээжүүдээ зорьдог доо. Ер нь Сар шинийн баяраар аль болох шинийн өдрүүдэд багтаж ахмад настуудынхаа амар мэндийг эрж, золгохыг эрхэмлэдэг.

**Зочдын хөлд хэр “дарагддаг” вэ?**

-Бусдын л адил, аав ээжүүд, дүү нар, ах дүү, амраг садангууд зочилдог. Хэдэн өдөртөө л хөл хөөрцөг болдог юм.

**Сүүлчийн асуултыг Таны мэдэлд үлдээе ...**

-Баярлалаа. Юуны өмнө хайртай аав, ээжүүддээ, ханьдаа, хөөрхөн хүүхдүүддээ, “Соёмбо” сониний нийт уншигчдадаа, тэр тусмаа “Алдар” спорт хорооны болон Африкт мөр зорьсон үүрэг гүйцэтгэж байгаа батальоны удирдлага, хамт олондоо учран золгож буй “Хотол төгс” хэмээгч төмөр хулгана жилийн Сар шинийн баярын мэндийг өргөн дэвшүүлэе. Та бүхэн минь элгээрээ энх амгалан, төрлөөрөө түвшин амгалан сайхан шинэлээрэй. Эрдэнийн зүйлсээр бөөлждөг хэмээн бэлгэддэг хулгана жилдээ Та бүхэн минь эд баялгаар арвин, эрүүл мэндээр баян байх болтугай.

## Ч.Дарьсүрэн: СӨРЖ ЗОГСОЖ БАЙЖ Л АМЬДРАЛЫН УТГА УЧРЫГ МЭДЭРНЭ



**Юуны өмнө Та манай уншигчдад өөрийгөө танилцуулна уу?**

-Намайг Чулуунбаатарын Дарьсүрэн гэдэг. Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Төлөвлөлт, зохион байгуулалт, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч цолтой.

**Ажиллагааныхаа тухайд тодруулна уу?**

-Манай цагдаагийн байгууллага энхийг сахиулах ажиллагаанд бие даасан офицер илгээн үүрэг гүйцэтгүүлдэг гурав дахь жилийнхээ нүүрийг үзэж байна. Миний хувьд анх удаа үүрэг гүйцэтгэж байна. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхэд тухайн алба хаагч нь тусгай чиг үүргийн аль албанаас томилогдон ирж байгаагаас хамаарч, хүний нөөцийн тусгайлан сонгон шалгаруулалтын үе шатыг давж тэнцсэний эцэст ажиллагааны газар оронд ирж ажилладаг. Цагдаагийн алба хаагчдын хувьд гүйцэтгэх чиг үүргийн онцлогоосоо хамаарч өөрийн улс орондоо ямар ч өндөр албан тушаал, цол өндөртэй байсан ч ажиллагааны газар оронд ирсэн даруйдаа РОС (Дотоодын зөвлөх офицерын үүргийг тодорхой хугацаанд заавал гүйцэтгэнэ. Үүний дараа нээлттэй зарласан ажлын байранд мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлагаараа өрсөлдөн дараа дараагийн албан тушаалд томилогдон ажиллах боломжтой байдаг. Энэ журмын дагуу анх Жуба хотын РОС-д сар гаруй ажиллаад мөрдөн байцаалтын чиглэлээр Монголдоо ажилласан туршлагаа үндэслэн ажлын байрны сонгон шалгаруулалтад өрсөлдөж, гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах тасагт 11 сар ажилласан. Ингээд дахин сонгон шалгаруулалтад өрсөлдөж тухайн ажиллагааны Хүний нөөцийн газарт “UNPOL” хариуцсан санхүүгийн хяналт шалгалтын офицероор үүрэг гүйцэтгээд эх орондоо буцах гэж байна.

**НҮБ-ын хэмжээнд монгол цэргийн нэр хүнд ямар байдаг талаар та тодотгохгүй юу?**

-Зөвхөн НҮБ-д гэлтгүй дэлхийд монгол цэргүүд нэр хүнд маш өндөртэй. Тэдний маань үймээн самуун, дайн тулааны хөлд нэрвэгдсэн ард иргэдийн төлөө амь биеэ үл хайхран яваа сэтгэл, зүтгэлийг мэддэг учраас дэлхийн ард иргэд нийтээрээ хүндэлдэг, хайрладаг болсныг ажиллагааны газар оронд ирж ажиллаад илүү ихээр ойлгосон, бүр монгол цэргүүдийнхээ хүрсэн тэр их нэр хүндээс Монгол Улсын иргэн, монгол хүн гэдгээрээ хуваалцаж явна. Ажиллагааны Хүний нөөцийн газарт томилогдоод шинэ хамт олондоо өөрийгөө Монголын цагдаагийн офицер гэдгээ хэлж танилцуулахад Өмнөд Суданы эмэгтэй ажилтан маань “Монгол цэргүүд ирээд манай оронд энх тайван тогтоож байгаа, одоо монгол цагдаа нэмэгдэж бүр амар амгалан болох нь, танай монгол цэргүүд манай оронд ирээгүй бол бид дайн тулаан, үймээн самуунтай хэчнээн ч жил болох байсныг таашгүй, танай цэргүүд ирснээр бидэнд ийм боломж олдож байгаад баяртай

байгааг маань цэргүүддээ уламжилж хэлээрэй” гээд тэврэхэд нь үнэхээр бахархалтай байсан. Үүрэг гүйцэтгээд буцаж байгаа ялангуяа Бентью мужид ажилласан гаднын орны цагдаагийн алба хаагчид бүгд л “Танай монгол цэргүүд хамгийн шилдэг нь, тэдэнд ямар ч үед найдаж болно, хамгийн хүнд нөхцөлд цэрэг хүн ийм л байх ёстой гэдэг үлгэр дуурайллыг бодитоор нь үзүүлж чаддаг” гэх мэтчилэн сэтгэгдлээ илэрхийлдэг. Үүрэг гүйцэтгэх хугацаандаа монгол цэргүүдийнхээ талаар эерэг сайхан сэтгэгдлүүдийг орон нутгийн төдийгүй бусад орны цэрэг, цагдаагийн алба хаагчдаас олныг сонсож байлаа.

**Энэ улс орны ард иргэд тэр тусмаа эмэгтэйчүүдийнх нь тухайд та юу хэлмээр байна вэ?**

-Хэрэв бурхан байгаад, миний үгийг сонсдог бол өршөөж энэрч, харж хандах ёстой хүмүүс чинь энд л байна шүү гэмээр. Энэ орны иргэд өөрсдөө хүссэндээ ийм амьдралыг сонгоогүй, хэн нэгний санаатай, санамсаргүй гаргасан алдааны золиос бүхэл бүтэн улсыг үгүйрүүлж, сүйрүүлэхэд хүргээд зогсохгүй хамгийн хүнд нь эмэгтэйчүүд, хүүхдүүдэд тусч байгааг өөрийн нүдээр харж мэдэрлээ. Энэ аймшиг үүгээр л дуусаасай. Хүн хайр даахгүйн зовлонд унасан мунхаглал, хувиа хичээсэн, шунал хүсэлдээ автаад бурхан байгаад ч тусалж чадахгүй ийм нөхцөл байдлыг дахин бүү үүсгээсэй.

**Эх орноосоо, гэр бүлээсээ хол удаан хугацаагаар байх мэдээж хэцүү ...**

-Хэцүү, гэхдээ сөрж зогсож байж л амьдралын утга учрыг мэдэрнэ шүү дээ. Ялангуяа ар гэрээсээ хайртай дотнын хүнээ алдаа гэх муу мэдээ хүлээн авах маш аймшигтай. Гэвч зовлон дааж хатуужиж байж л хүн болно, ухаан сууна. Аавын минь буруу юу байх вэ, гэхдээ намайг арай л их эрхлүүлж өсгөж дээ гэж бодох болсон.

**Эх орны үнэ цэнийн тухайд ...**

-Монголчууд хамгийн хувьтай, азтай ард түмэн. Өвгөд дээдсийнхээ холч ухаанаар элдэв гай зовлон туулалгүй өдий хүрлээ. Одоо энэ хувь заяандаа эзэн болж, үр хүүхдэдээ өвлүүлэх юм сан.

**Ярилцлагын төгсгөлд Та юу хэлэх вэ?**

-Манай монголчууд орчиндоо захирагдаж, түүндээ дасан зохицож биш, амьдрах тав тухтай орчин нөхцөлөө өөрсдөө бүтээн байгуулж, амьдралыг баяжуулж амьдардаг ард түмэн. Энэ уламжлал ч Монгол Улсын Зэвсэгт хүчний мотобуудлагын батальоны эргэн тойронд тасраагүй, ажиллаж, амьдрах орчин нөхцөлөө хэрхэн бүрдүүлсэн нь бусдаас илт ялгарч харагддаг. “Энэ чинь л монголчууд, монгол цэргүүд шүү дээ” гэж бусдад баярхмаар санагддаг. Хүрээд ирэхэд хэдий хүний газарт байгаа ч халуун дотно уур амьсгал, эх орондоо, гэр орондоо, гэр бүл, элгэн садан дундаа байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг. “MONBATT IX”-ийн нийт бие бүрэлдэхүүнд 2020 ондоо энхийг сахиулах нэр хүндтэй үүргээ амжилттай гүйцэтгээд эх орондоо баяртай үулзахын ерөөлийг дэвшүүлэе.

Өмнө

# ТАНИЛ ДОТНО



## ТАВАНТОЛГОЙ

Энэ танил замаар хэдэн удаа явж, тэр газар хэдэн удаа очиж байгаагаа мэдэхгүй. Нэлээд тоо гарах байх. Харин манай цэргийнхэн бол миний очсоноос хэдэн 10 удаа илүү очсон байж таарна. Ямар зам, ямар газар юм бол гэж таамаглаж ядаж байна уу? Та бидний хувьд танилаар барах уу, бүр дотнын гэж хэлж болох Тавантолгойн тухай бичиж сууна. Тавантолгой гэхээр таны сэтгэлд юу бууж байна вэ? Талд дэрвэх майхнууд, талаар нэг тархсан "эрээн хувцастнууд", хээрийн гаралт, хоногийн сургууль, олон улсын цэргийн сургууль, дадлага, сургалт бэлтгэл гээд цэргийн хөдөлмөрийн талбар нүднээ үзэгдэж, олон дурсамж хөвөрч байгаа нь лавтай. Заримынх нь хувьд бараг хоёр дахь гэр нь болчихсон газар. Мөн заримынх нь хөдөлмөр зүтгэл, хичээл чармайлтын үр дүн, амжилт ололт бүхэн энэхүү газартай холбоотой гэдэг нь мадаггүй. Миний хувьд "Марш тактикийн тэмцээн" л хамгийн түрүүнд сэтгэлд буугаад байдаг юм. Арваад жилийн өмнө анх Тавантолгойг зорьж байснаа огт мартдаггүй. Энгийн сургууль төгсөөд цэргийн салбарт ажилд орсон надад Тавантолгойд болох маршийг сурвалжлах томиллолт өгөн хэн нэгэн даргын 69-д /УАЗ-469/ суулгаад явуулчаж билээ. Ямар газар

ямархуу тэмцээн болдог юм бол доо гэсэн асуултыг өөртөө тавьж, хоосон төсөөлж, эмээсхийж явлаа. "69"-д хамт яваа хүмүүсээ ч танихгүй, зам зуур ганц хоёр үг солин арай нүүр хагарсныхаа дараа "Яагаад "Тавантолгой" гэж нэрлэсэн юм бол ..." гэсэн чинь урд талын суудалд тухалсан дэд хурандаа "За тэр чинь их гүн гүнзгий утга агуулгатай даа. Таван ширхэг толгой бий. Нэг нь "Сахал Бороогийн толгой" (Хошууч генерал Н.Борбаатар агсан. Тухай үед ЗХЖШ-ын Сургалт, зохион байгуулалт эрхэлсэн орлогч дарга байсан) хоёр дахь нь "Халзан Золоогийн толгой" (Булган аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Х.Золзаяа. Тухай үед ЗХЖШ-ын Цэргийн сургалтын хэлтсийн биеийн тамир, спорт хариуцсан ахлах мэргэжилтэн байсан) гурав дахь нь "Буурал Цогоогийн толгой" (ЗХЖШ-ын Сургалтын хэлтсийн биеийн тамир, спортын тасгийн дарга, хурандаа Д.Цог-Эрдэнэ. Тухайн үед "Алдар" спорт хорооны орлогч дарга байсан), дээр нь тэнд хоёр сайхан хайрхан бий. Энэ тавын толгой асуугаад байгаа тэр газрыг чинь чимэглэдэг болохоор л "Тавантолгой" гэж нэрлэсэн юм

даа" гэхэд хамт явсан хүмүүс нэр хийтэл инээлдэж билээ. Надаар даажигнасан энэ хариулт одоо ч надад дотно дурсамж авчирдаг юм. Угтаа бол баруун аймгуудын малчид улсын хэмжээний мал, мах бэлтгэлд зориулж малаа авч ирдэг тууврын зам энэ нутгаар дайрдаг байсан юм гэнэ лээ. Хожим буюу 1970-аад оны үед Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарч артиллерийн буудлага хийх тусгай хэрэгцээний газар болгосон талаар учир мэдэх хүнээс сонссон. Нэрийн хувьд бол Очир толгой, Өгөөмөр толгой гэх зэрэг нутгийн уул хайрхнуудаас л үүдэлтэй байх. Тэр үед Сургалтын нэгдсэн төв одоогийнх шиг тохижилттой байгаагүйг надаар хэлүүлэлтгүй мэднэ дээ, манайхан. Ангийн томилгоот бүрэлдэхүүн жигдрэн буугаад "битүү морьдоо" сойчихсон, майхны гадаа утаа суунаглан хоол, ундаа хийж, тэмцээний бэлтгэлээ хэзээний хангачихсан, тэмцээн болох өдрийг хүлээн суугаа торгон цаг мөч. Тэнд л би цэргийн хөдөлмөрийн хүнд хэцүүг, бахархал омогшил, ялалтын үнэ цэн, ялагдахын гашуун амт, нөхөрлөл, өрсөлдөөн гээд маш олон дүр зургийг харж

алмайрч байснаа мартдаггүй юм. Магадгүй оюутны ширээнээс салаагүй шахам надад тэгж санагдсан ч байж болох. Тэнд л би нөхрөө түшин барианд орж буй дайчдыг, уухай хашхиран гүйн ирж буй цэргүүдээ тэврэн үнсэх захирагчийг, адуу шиг гүйж чадлаа гайхуулах "элит"-ийн охидыг, хожигдсондоо шаралхан нулимсаа шударч буй салааны залуухан захирагчийг, алтан медалиас атгаад алдсан багийн харууслыг, ялалтын тавцанд омог бардам зогсож байгаа дайчдыг, хамт олноо уухайлан дэмжиж бор цай, усаа барин зогсох нөхдийг, хоцорсон нэгнийгээ буруутган нудрах хортой, шартай хөвгүүдийг харж хамт баярлаж, бас гуниглаж, харамсаж, хачин мундгийг нь гайхаж, хүндэтгэх сэтгэлээ урсаж байж билээ. Одоо ч ялгаагүй зорин очиж энэ дүр зургуудыг харах туйлаас дуртай. Хаа холын Ховдын хорооноос маршид оролцож байгаа байлдагчийг аав, ээж хоёр нь дагаад ирчихсэн барианд оров уу, үгүй юу хоёр талаас нь зүүгдэн үнсэж хүүгээрээ бахархан нулимс унагаж буй сэтгэл догдуулсан агшныг энд л хамт мэдэрсэн. Тооцоод байвал олон. Хүн хүнд өөр

өөрийн гэсэн дурсамж сэтгэлд нь тодорч байгаа байх л даа. За тэгээд нөгөө таван толгойн хоёр нь болох Цогоо хурандаа, Золоо хурандаа нар бол одоогийн хэллэгээр "баавар"-тай даа. Мэдэхгүй, чадахгүй гэхийн зовлонгүй, ёстой л Тавантолгойн эзэд гэмээр. Тэр хоёргүй юм гэж тэмцээний үеэр лав байхгүй. Энэ хоёр "толгой"-н үүрэг, оролцоог хэн хүнгүй сайн мэдэх биз дээ. Илүү дутууг нурших хэрэг ч байхгүй. Дурсав уу, үгүй юу, дүр зураг нь шууд л бууж байгаа байх.

За тэгээд Тавантолгойг зорих машин тэрэгний жолооч нар тэр дундаа "089"-ийн жолооч нар бол худалч хүнд Тавантолгой хүрэх замын хаана нь ямар чулуу байгааг ч бараг мэднэ дээ. Нүдээ аниад жолоогоо мушгихад ч олоод оччихно гэхэд хилсдэхгүй. Цэргийнхэн бидний хувьд ийм л дотно газар даа, бидний Тавантолгой. Зориод очиход хийморь сэргэдэг, зорьсон зорилгоо биелүүлээд буцсан ч сэтгэлд үлддэг танил дотно Тавантолгой минь сайхаан, сайхан.

Хошууч Х.ГАНЗУЛ

### ТЭД БИДНИЙ ТУХАЙ

ИБНАУ-д явагдаж буй "Шийдвэртэй дэмжлэг" олон улсын ажиллагаанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн хамгаалалтын ротын Х ээлжийн бие бүрэлдэхүүн бусад орны алба хаагчидтай нөхөрсөг, найрсаг харилцаатай байдаг билээ. Тэдний зарим төлөөллийн сэтгэгдлийг хуваалцсан юм.

## МОНГОЛД ЗОЧЛОХЫГ МАШ ИХ ХҮСЭЖ БАЙНА

Та өөрийгөө танилцуулна уу?

-Намайг ахлагч Бом Бахадур Гүрүнг гэдэг. Би Их Британийн Хатан хааны армийн Ёоркширийн ангийн хоёр дугаар батальонд алба хаадаг. 2004 онд Их Британийн армид "Балбын Гурка"-ийн ангид анх элсэж цэргийн алба хаагч болсон. Тэндээ есөн сарын бэлтгэлд хамрагдаад улмаар 11 жил алба хаасан. Одоогоос таван жилийн өмнө Ёоркширийн ангид томилогдсон. Хоёр дахь удаагаа хилийн чанадад үүрэг гүйцэтгэж байна. Өмнө нь Афганистан улсын Хэлманд мужид үүрэг гүйцэтгэсэн.

Та 16 жил Их Британийн армид алба хаахдаа олон орны цэргүүдтэй хамт үүрэг гүйцэтгэж байсан байх. Монголчуудтай ажиллаж байв уу?

-Миний хувьд өмнө нь монголчуудтай ажиллаж байгаагүй. Гэхдээ Хэлманд мужид үүрэг гүйцэтгэж байхад монгол гаралтай гэгдэх хазарачуудтай таарч байсан. Тухайн үед их тааламжтай сэтгэгдэл төрж байлаа. Энэ удаагийн ажиллагааны бэлтгэл дээр бидэнд монгол, дани, австраличуудтай хамтран ажиллана гэдгийг хэлж байсан. Гэхдээ тухайн үед би монголчуудтай ийм ойрхон хамтран ажиллана гэж бодоогүй. Анх Кабулд монголчуудтай таарахад яагаад ч юм хамтран ажиллахад тун амар байх болов уу гэж бодогдсон. Одоо бол хэлний бэрхшээлээс өөр ямар ч асуудалгүй, хамтран ажиллахад тун тааламжтай байдаг. Монголчууд таарахаараа "Хөөе Бом" гээд л маш эелдэг ханддаг. Харин Дани эсвэл Америкийн цэргийн алба хаагчид барагтай бол мэндэлдэггүй. Шинэ Кабул



баазад маш олон монгол найз нөхөдтэй болсон.

Таны төрсөн нутаг Балба улсад монгол гаралтай хүмүүс олон байдаг гэж сонссон. Энэ талаар ярьж болох уу?

-Балбад бурхны шашинтай овог, аймгууд өөрсдийгөө монгол гаралтай гэж үздэг. Би өөрөө тэр овог, аймгаас гаралтай. Балбачуудын бараг тал хувь нь дугуй нүүр, монхор хамар, жартгар нүд, хар үс, хөрслөг бор арьстай, монголчуудтай төстэй төрхтэй. Энэ ч утгаараа надад монголчууд илүү элгэмсэг, дотно санагддаг байх. Хамгийн анх монголчуудыг хараад л миний ахан дүүс байна шүү дээ гэж уулга алдсан. Бидний хувьд хоорондоо их адилхан.

Та балба хүн боловч Их Британийн армид алба хаадаг. Хоёр өөр соёл, цэргийн уламжлалтай орны гүүр нь болж явдаг. Хоёр орны цэргийн алба хаагчдын сул болоод давуу талуудын талаар ярьж болох уу?

-Их Британи, Франц зэрэг өрнийн орнуудын арми Монгол, Балба, Энэтхэг зэрэг дорнын улсуудын армиас ихээхэн ялгаатай. Бидний хувьд удирдах албан тушаалтантайгаа харьцахдаа хүндэтгэсэн өнгөөр, нам дуугаар ярьдаг. Харин өрнийн орнуудын армийн хувьд дээд албан тушаалтантайгаа анд нөхөр шиг харилцдаг. Миний хувьд энэ хоёр өөр арга барилаар хоёулангаар нь ажиллаж сурсан. Эхлээд зөвхөн балбачуудаас бүрдсэн Гурка ангид байхдаа би анд нөхөдтэйгөө нэг янзаар, харин илүү цолтой хүмүүстэй өөрөөр харилцдаг байсан. Харин англичуудаас бүрдсэн Ёоркширийн ангид очсоныхоо дараа бүх хүн цолноос үл хамааран хоорондоо найзууд шиг ярихад надад эхлээд маш сонин санагддаг байлаа. Аль аль арга барил нь давуу болон сул талтай. Дорнын армиудын өөрөөсөө ахмад цолтой хүний тушаалыг үг дуугүй хүлээж авдаг, сахилга баттай байдаг зэрэг чанар нь дайны нөхцөлд ажиллагааг илүү амжилттай гүйцэтгэхэд чухал ач холбогдолтой. Харин ажиллагаа явуулж байгаа орны ард түмэнд өөрсдийн байр сууриа зөвөөр ойлгуулах, олон талын яригтай асуудлыг зохицуулахад өрнийн армийн бүх хүн биеэ дааж ажилладаг хэвтээ тогтолцоо илүү үр дүнтэй.

Та хэзээ Монголд зочлохоор төлөвлөж байна вэ?

-Би Монголд зочлохыг маш их хүсэж байна. Үүнийг зүгээр эелдэг зан гаргаж хэлж байгаа юм биш шүү. Миний хувьд Монголын тухай бодох бүртээ өргөн уудам тал нутаг ногоон зүлэг халиурч, адуу мал багширч, хундан цагаан гэр цоохортож, баяр жаргалтай ард олон наадаж байгаагаар төсөөлдөг.

## МОНГОЛ ЦЭРГҮҮД БОЛ ШАЛГАРСАН ШИЛДЭГ ДАЙЧИД

АНУ-ын холбогч офицер ахмад Ванс Жонсон АНУ-ын Аляска мужийн нөөцийн армид ажилладаг. "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаанд Монгол Улсын цэргийн хамгаалалтын ротын холбогч офицерын албан тушаалд үүрэг гүйцэтгэж байна.

Ахмад ВАНС ЖОНСОН:

-Монгол Улсад зохион байгуулагдсан "Хааны эрэлд-2012", "Говийн чоно-2014" олон улсын сургуулиудад оролцож, монголчуудыг илүү их мэдэх болсон. Анх 2012 онд очихдоо Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд монгол гэрт байрлаж байсан бөгөөд үндэсний хоол, уудам их тал нутаг гээд үнэхээр зүйрлэхийн аргагүй сайхан уламжлал, байгалийг нь



биширсэн. Ялангуяа өглөөний гүйлтийн үеэр мэдэрдэг цэвэр агаар, тийм гэж хэлэхийн аргагүй сайхан үнэр, салхийг нь мартагын аргагүй. Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдыг өгөгдсөн үүрэг, даалгаврыг ямар ч нөхцөлд чадварлаг биелүүлдэг шалгарсан шилдэг цэргүүд гэж боддог.

## МИНИЙ МОНГОЛ НЭР БОЛДОО

"Шинэ Кабул" баазын гэрээт ажилтан ЖАКСОН ИРЭНГҮЙ МАТБЭН



Өөрийгөө товч танилцуулахгүй юу?

-Би БНӨСУ-ын Бентью мужаас ирсэн. Эхнэр, дөрвөн хүүхдийн хамт амьдардаг. Том хүү маань их сургуулийн төгсөх ангийн оюутан, бусад хүүхдүүд маань 10 жилийн сургуульд суралцдаг.

Монголын цэргийн алба хаагчдын талаар хэзээнээс эхэлж мэдэх вэ?

-Дөрвөн жилийн өмнө Бентью мужид монгол цэргүүдтэй уулзаж байсан. 2017 онд ИБНАУ-д анх ирэхэд бас л Монгол Улсаас шинээр цэргийн баг ирж таарсан. Тэд надад их ойр санагдаж дарга, цэрэг гэлтгүй бүгд намайг хүндэлж байсан учраас монголчуудтай дотно нөхөрлөж эхэлсэн дээ.

Танд монгол нэр хүртэл өгсөн юм байна ...

-Болдоо гэдэг нэрийг нэг монгол цэргийн дарга өгсөн, нэрийг нь сайн санахгүй байна. Тэр дарга надтай их ойр дотно, нөхөрсөг харилцдаг байсан. Би Монгол Улсыг надтай харилцаж байгаа цэргүүдийнх нь сэтгэл шиг сайхан, уудам цэлгэр нутагтай, ард түмнийг нь их хүнлэг сэтгэлтэй гэж боддог. Монголын энхийг сахиулагчид манай улсад хоёргүй сэтгэлээр тусалж байгаад баярладаг. Сониноор дамжуулан өмнө нь уулзаж байсан монголчууддаа сайн сайхныг хүсэн ерөөе.

Ахлах дэслэгч Б.МӨНХТУУЛ

ОННГОХ АРХИВ

(Түрүүч нь I нүүрт)

## НЭРД ГАРСАН АЛДАРТНУУДЫН ОЛОНХ НЬ УНАГАН АВЬЯСТАЙ

Гавьяат жүжигчин Гончигийн Тэрбиш Говь-Алтай аймгийн Жаргалант сумын уугуул, нийслэл хотын суугуул. Тэр бээр аккордион хөгжмийг өвөр дээрээ анхлан залснаас хойш 59 дэх жилдээ хөгжимдөж, монголдоо төдийгүй дэлхийд танигдсан авьяаслаг уран бүтээлч юм. Түүнээс хөгжимтэй анхлан нөхөрлөсөн хүүхэд насны дурсамжийг нь хуваалцахад, 5 настай байхаас аман хуур хөгжмийг сонирхож, тэр үеийн сумын клубийн эрхлэгч Чойдог, багш Осоржамц нарын дэмжлэгтэйгээр аман хуур, гармонь хөгжмийг тоглож сурсан

Авьяаслаг залуу хөгжимчин тэр бээр 1969 оны намар мэргэжлийн найрал дуу буюу алдарт жаран харыг үүсгэн байгуулах үед Цэргийн ансамблийн алтан босгыг алхаж орсон ба энэ л үеэс анхны уран бүтээлээ туурвиж эхэлсэн аж. 1965 онд нутгаасаа мордож, Улаанбаатар хотын Шувуун фабрикийн клубийн хөгжмийн багшаар ажлын гараагаа эхэлсэн ба 1967 оноос Барилгын цэргийн 012 дугаар ангид хөгжмийн салааны байдлагчаар алба хааж, энэ хугацаандаа удалгүй салааны захирагчаа орлон сурагчдаас голдуу бүрдсэн найрал хөгжимчдөө удирддаг байжээ.

Түүний зохиосон анхны дуу нь Цэргийн ансамблийн баян хуурч, яруу найрагч П.Лувсангийн шүлгээр "Сайн байна уу, ээж ээ" хэмээх дуу юм. Энэхүү шинээн дуугаа 1969 онд гавьяат жүжигчин Н.Отгоноор



# ХӨӨРӨГТ ХӨГЖМИЙН ЭГШИГЛЭХҮЙ ДОР ...

# ХААН АЯЛГУУ

гэх ба түүний төрөлхийн авьяас балчир насанд нь тодорсон байх юм. Энд өгүүлэн буй Чойдог багш нь хожмоо Говь-Алтай аймгийн "Алтай" чуулгын ёочин хөгжимчин, хөгжмийн найралжуулагч багшаар олон жил ажиллажээ. Харин Осоржамц багш нь ноот мэдэхгүй мөртлөө хөгжмийг тун чадварлаг тоглодог байсан бөгөөд хожмоо Буянт-Ухаа дахь Нисэхийн тусгай үйлчилгээний авто баазын даргаар ажилласныг онцолж байсан юм.

Нийтлэлийн баатар маань 1960 онд Говь-Алтай аймгийн Жаргалант сумын бага сургуулийг дүүргэж, улмаар аймгийн төвийн арван жилийн дунд сургуульд суралцаж байхдаа нутаг усандаа "Ган Рагчаа" хэмээн алдаршсан ачит багшийнхаа ангид элсэн суралцжээ. Тэрээр энэ л багшийнхаа дэмжлэгээр гармонь хөгжмөөр олон арван аялгууг эгшиглүүлэн түүнийг нь хичээлийн завсарлага бүрээр сургуулийн радио узелиээр нэвтрүүлэн багш, сурагчдыг соён гэгээрүүлж явсан нь дурсамжтай. Энд өгүүлэн буй Рагчаа багш нь түүнийг хичээл тарангуул л гармонь хөгжмөө хөгжимдөхийг нь хүсдэг, бусад багш нар, найз нөхдөө дуудаж сонсгодог байжээ. Энэ үед анги даасан багш нь сурагч Г.Тэрбишээс Оросын алдарт хөгжмийн зохиолчдын зохиол, бүтээлээс мөн казах үндэсний дуу, хөгжмөөс тоглохыг хүсдэг байжээ. Үүний учир нь багшийнх нь гэргий казах бүсгүй байсантай холбоотой ажээ. Багш Рагчаа нь сүүлд Улаанбаатар хотноо "Сайд нарын" хэмээх тодотголтой хоёрдугаар төв эмнэлгийн орлогч даргаар ажиллах хугацаандаа мөн л гавьяат шавиа урьж, эмнэлгийнхээ эмч, ажилтнуудын концертыг бэлтгүүлэн хамтарч ажилласан нь бас л сонин тохиолдол.

Гавьяат бид хоёр хөөрөлдөж суухдаа "Танай удамд хөгжимчин хүн байгаа юу?" хэмээн тодруулахад, "Үгүй ээ бидний удамд хөгжимчин огт байгаагүй, аав Д.Гончиг маань уртын дууг сайн дуулдаг байлаа. Харин төрсөн ах Г.Дорждагва манай аймгийнхны огт мэддэггүй уртын дууруудыг уянгалга сайхан дуулдагараа нутаг усныхандаа алдартай нэгэн" гэж хариулж билээ. Гавьяатын маань аав Гозгор Гооёо хэмээх нь ихэд заргач бас бариац хүн байсан ба худам монгол бичгээр өргөдөл бичээд хэрэгт орсон хүнийг ч суллаад гаргаж явсан удаатай аж. Түүний хэлснээр аавыг нь хүндэлж, сар шинийн баяраар золгож буй хүмүүсийн дотор "Авсан ээж" хэмээн хүндлэх хүн олон байдаг бөгөөд учир нь тухайн үед сум, орон нутагт эмнэлэг, эмч хүрэлцэхгүй үед тэрээр өөрийнхөө мориор очиж, "шинэ хүнийг өлгийдөх" буянтай агаад хүндтэй үүргийг гүйцэтгэж явснаар нь бахархдаг гэж онцлон өгүүлсэн.

Түүнээс та өдий зэрэгтэй яваагаа юутай холбож тайлбарладаг вэ хэмээн асуухад нэгдүгээрт, ичимхий зан, хоёрдугаарт, бие даасан байдал, гуравдугаарт хүмүүнлэг ёс жудаг, найз нөхдөө цаг үргэлж хүндэтгэх чадвар, дөрөвдүгээрт, аав, ээжийн маань амин захиас, ардын сургаал үгс хэмээн тодотгосон. Мөн олон сайхан багш нар Д.Мяасүрэн, Д.Бадарч, Ш.Гунаажав, П.Хаянхярваа, найрал дууны орос багш, хөгжмийн зохиолч А.Онекин, В.Ф.Мищенко, В.А.Фёдоров нарыг ихэд хүндэлдэг гэж билээ.

**АНСАМБЛЬ ОРЖ, АНХНЫ ДУУ ТӨРСӨН ТУХАЙД**

дуулуулснаар уран бүтээлийн анхны шагналаа гардаж, ичих, баярлах хоёр зэрэгцэн байсныг олон хүн ам уралдан ярих юм билээ. Тухайн үед Г.Тэрбиш 300 төгрөгийн цалин авч байсан бол уран бүтээлийг нь "Сайн" хэмээн үнэлж, 90 төгрөгийн шагнал олгожээ. Харин тэр үед "Онц" үнэлэгдсэн бүтээлд 100 төгрөг олгодог байсан нь аливаа уран бүтээлчийн идэвхийг өрнүүлсэн, уран бүтээлийн чанарыг ахиулсан дэвшилтэт арга байсан нь надад мэдрэгдсэн юм.

Түүнд 1980-аад оны үед Төрийн хошой шагналт Л.Мөрдорж гуай "Хүү минь очсон газар бүртээ дуу зохиож яваарай" хэмээн итгэл хүлээлгэн захижээ. Түүний хувьд ихэд ичингүйрч, хэн надад ямархан шүлэг бичиж өгч, би түүнд нь зохируулан хэрхэн ая зохиож барах билээ, багш маань намайг цаашлуулж байна даа хэмээн өөрийгөө голж явсан нь саяхан. Гэтэл багшийнх нь тэрхүү ерөөл биеллээ олж, өдгөө 510 гаруй тооны хөгжмийн бүтээлтэй болсон нь бахархууштай. Тэдгээрийн сэдвийг нь сонирхоход дан хөгжмийн бүтээл-20 гаруй, найрал дуу 10 гаруй, зохиолын дуу 300 гаруй, мэргэжлийн дуу 100 гаруй, бүжгийн хөгжмүүд 30 орчим, бүтээсэн чуулбар буюу титмүүд 10 гаруй зэрэг бүтээлийг жагсааж болохоор аж. Тэдгээрийн дотроос "Сайн байна уу, ээж ээ", "Эрэн нуур", "Наадмын морьдын тоос", "Наран доторх наадам", "Увс нуур", "Ганга нуур", "Найман нуур", "Дэлгэр мөрөн", "Гал шарын унага", "Тольтой мөнгөн эмээл" зэрэг дуу нь бидний сэтгэлд нэн хоногшжээ.

### ЗӨВХӨН НЭГ ЖИЛД ...

Түүний хувьд улиран одсон он жилүүдэд уран бүтээлийн ганзага дүүрэн байсныг мэдрэх хүн олон биз. Энд жишээ татахад, зөвхөн өнгөрөгч 2019 онд л гэхэд түүний уран бүтээл амжилтаар дүүрэн байлаа. Тэдгээрийн дотроос онцлобоос өнгөрөгч онд Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын уран бүтээлчид мэргэжлийн найрал дуу үүсэж хөгжсөний 50 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэсэн. Энэхүү баярыг угтсан бүхий л ёслолд эрхэм гавьяат маань уригдаж оролцсон. Энэ үеэр жанжин Д.Сүхбаатарын хөшөөний дэргэд "Жаран хар"-ынхан хэмээн алдаршсан мэргэжлийн найрал дуучдын дуулсан С.Гончигсумлаагийн хөгжим "Сүхбаатарын алдар" дууг гоцлон хөгжимдөж, тэрхүү түүх мөнхөлсөн гэрэл зургаа гэрийнхээ хойморт залжээ. Тэрчлэн тус чуулгын мэргэжлийн холимог найрал хөгжмийн 60 жилийн ойн концертод ахмад, дунд, залуу үеийн нийт хөгжимчдийн хамтаар оролцсоны зэрэгцээ Д.Бадарчийн хөгжим "Бүүвэйн дуу"-гаар сэдэвлэн зохиосон найрал хөгжимтэй бүтээлийг аккордион хөгжмөөр гоцлон хөгжимдөж кино концертод мөнхөлсөн нь бас л нэг дурсамж болон үлдсэнийг гавьяат маань дурсаж билээ.

Тэрчлэн 11 дүгээр сарын 10-ны өдөр бөхийн "Увс нуур" галын тэргүүн, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайд Д.Цэрэнбатын урилгаар "Увс нуур" дууны хөшөөг босгох үйл ажиллагаанд гэргий Н.Больхүүгийн хамтаар оролцсон нь хэзээ ч мартагдашгүй үйл явдлынх нь нэг. Дашрамд, түүний эхнэр Намдагийн Больхүү нь сэтгэл зүйч эмч, өнгөт энерги зүйч эмч бөгөөд өдгөө олон

улсын "Планет Реганов" компанийн дэд захирлын албыг амжилт дүүрэн хашиж явааг энд дурдах нь зүй биз ээ. Энд тодруулахад, 1991 оны хавар Улаангом-Улаанбаатарын чиглэлд АН-24 онгоцоор зорчиж явах үедээ "Наран доторх наадам" хэмээх хоёр дууг зэрэг зохиожээ. Энэхүү "Увс нуур" дууг нь тус аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор "Аймгийн сүлд дуу"-гаар батламжлан Увс нуурын хөвөөнөө сансарт нартай нь хамт, газарт лустай нь хамт мөнхлөн залж, хойч үедээ өвлүүлэн үлдээсэнд чин сэтгэлээсээ талархсан нь мэдээж биз ээ.

### МОНГОЛ НЭРЭЭ МӨНХӨЛСӨН ДУРСАМЖУУД ...

Гавьяат жүжигчин Г.Тэрбиш дайчин нөхдийнхөө хамтаар Батлан хамгаалах салбарыг сурталчлах ажилд их явдаг байжээ. Тэрээр анхлан Зөвлөлт холбоот улсад, дараа нь БНХАУ, БНАСАУ, Япон, Бүгд найрамдах Болгар Ард Улс, Чехословак, Польш, Унгар, Румын болоод Латин Америк, Карибийн тэнгисийн орнуудаар ч аялан тоглолт хийж, гоцлол хөгжмийн зохист аялгуугаар гадаадын орны иргэдийг баярлуулж явсан нь бас л нэг бахархал. Энэ үед гадаад, дотоодын аль ч орон зайд цэргийн чуулгынхаа нэр хүндийг өндөрт өргөж явсан олон дурсамжийг нь ахмад уран бүтээлчид дурсан ярьдаг юм. Үүний нэгэн тод нотолгоо нь 1984 онд Чехословак улсын Батлан хамгаалах яамны сайд Мартин Зур генералын урилгаар Цэргийн дуу, бүжгийн ансамблийн уран бүтээлчид тоглолт хийх үеэр хүндэтгэлийн хүлээн авалт болсон ба тэдэнд цахилгаан аккордионтой нэгэн уран бүтээлч үйлчилжээ. Тэр үед Г.Тэрбиш цахилгаан аккордионыг нь сонирхож, тоглох зөвшөөрөл авмагцаа "Город Колин" хэмээх хөгжмийг тоглолт хүлээн авалтад оролцогч бүх дарга, генерал суудлаасаа босож хөгжим дуустал алга ташжээ. Учир нь түүнийг өглөө эртлэн босож, хөгжмийн сургуулилтаа хийх үед телевизээр Колин хотын 50 жилийн ойд зориулсан нэвтрүүлэг явсан бөгөөд дээрх аялгуулаар найрал хөгжимчид хөгжимдсөнийг нь цаасан дээр буулгасан хэрэг. Гэтэл орой нь хүлээн авалтын үеэр өнөөх ноот нь санаанд буусан ч зочид буудалдаа үлдээсэн болохоор шууд л тоглосон нь үлгэрийн мэт гайхалтай. Тэрхүү хүлээн авалтын дараагаар П.Хаянхярваа багш энэ хөгжмийг хаана сурсныг нь түүнээс лавлахад, "Өглөө сургууль хийж байгаад ноотолж авсан нь толгойд буужээ" хэмээн хэв нэг хариулсан аж. Энэ үед Хаян багш "Овоо эр байжээ" гээд магтсан удаатай. Мөн тус улсын Олмоуц хотод нэгэн сүмийн аргон хөгжмийн мастер Шиндлер доктор тэрхүү хөгжмөөрөө хөгжимдөж үзүүлээд "Та бүхнээс хөгжимдөх хүн байна уу?" гэхэд нь чуулгын уран бүтээлчид Г.Тэрбишийг түлхээд гаргажээ. Тэрхүү аргон хөгжим нь дөрвөн мөчөөрөө хөгжимддөг өвөрмөц хөгжим байсан бөгөөд "Мартен" хэмээх хөгжмийн зохиолыг мань эр тогложээ. Түүнийг тэрхүү аялгууг тоглож дуустал өнөөх "том" багш мэл гайхаж, цэл хөхрөв бололтой чуулгын хамт олонд гүн талархал илэрхийлсэн баримтыг дурдаж болох юм.

Улмаар тэд маргааш өдөр

нь Унгар улсыг зорьж, галт тэргээр явах замдаа тэрхүү улсад тоглох урлагийн үзүүлбэрээ бэлдсээр явжээ. Эрхэм гавьяат маань цэргийн чуулгын тоглолтын үеэр унгар ардын дууны "попури"-ийг гоцлон тоглоход үзэгчид өндөрөөр үнэлж дахиулахад нь А.Хачатуряны "Гаяней" хэмээх алдарт бүтээлээр гайхалтай бэлэг барьсан тухай хууч яриа ч бий. Тэр орой бас л хүндэтгэлийн хүлээн авалт болж, П.Хаянхярваа багшийн эртний танил Антонин Блаж нь Унгарын хошин театрын дарга болчихсон байж таарлаа. А.Блаж Хаян багштай хууч хөөрч байгаад "Би танай хөгжимчин залуугийн хамтаар дуулмаар байна" хэмээхэд нь багш ч зөвшөөрч, эрхэм Г.Тэрбиш хөгжмөө бариад боссон гэдэг. Түүнийг ямар дуу дуулах талаар асуухтай зэрэгцэн А.Блаж унгар ардынхаа дууг "фа" мажорт дуулаад эхлээд нь найруу хавсарга маягаар дагаж хөгжимдөөд хоёрдугаар багшаас нь эхлээд тэр л аялгууг нь дагаж хөгжимдсөн ба харин гуравдахь бадаг дээр нь ритм пассажаар чимэглэлээ хийж хөгжимдөөд дуустал дуучин эр алга ташиж, эрхэм зочид суудлаасаа босож, хүндэтгэл үзүүлжээ. Маргааш өдөр нь Хаян багш мөн л "Чи тэрхүү унгар ардын дууг хэзээ, хаана сурсан билээ" гэж асуухад нь "Дуулж байхад нь шууд сурлаа, тэгээд л хөгжимдчихлөө" гэжээ. Харин Хаян багш нь "Пээ надаас илүү сонсолтой байжээ" хэмээн толгой сэгсэрсэн гэх дурсамж ч байдаг юм.

### УРАН БҮТЭЭЛД ХЯЗГААР ҮГҮЙ

Нийтлэлийн баатар маань аливаа нэгэн сургуульд суралцаж, хөгжмийн онол эзэмшээгүй ч түүний унаган авьяас нь мэргэжлийн хөгжимчдөөс дутахааргүй хөтөлснийг энд тодотгох учиртай. Тэр ЗХУ-ын Москва хотын хөөрөгт хөгжмийн алдарт багш Альфрейд Мирекийн "Аккордион хөгжмийг өөрөө сурах", Болгар улсын Георгий Наумоновын "1 ба 2 дугаар судар", Унгар улсын Штван Кардошийн "Хоёр судар" зэрэг номуудыг бие даан судалж, өөрийгөө хөгжүүлсэн нь өнөөгийн залууст үлгэрлэл гэлтэй. Мөн цэргийн чуулгын баян хуурч, хөгжмийн зохиолч, найралжуулагч Х.Юмжав багшаас их зүйлийг сурснаа байнга л тодотгох юм билээ. Үүний цаад учир нь Х.Юмжав багш түүнд гадаадын нэрт хөгжмийн зохиолчдын хөгжмүүдийг эмхэтгэсэн номуу олноор нь өгдөг байсантай холбоотой аж.

Түүнээс хөгжмийн зохиолчдын олимп хэмээгдсэн "Морин хуур" наадамд хэрхэн оролцсон тухайд нь тодруулахад, 2005 онд хүүхдийн дууны төрлөөр нэрт яруу найрагч Ц.Чимэддоржийн 13 настай охин Ч.Мөнхжингийн шүлгээр "Би Монгол хүүхэд" дууг зохиож оролцсоноор дэд байрын шагнал хүртсэн. 2018 онд Н.Ганчимэгийн "Бурхан ээждээ" шүлгээр уламжлал, шинэчлэлийн аргаар зохиосон суман уртын дуу хэлбэрийн бүтээлээрээ гутгар байрын шагнал хүртсэнээ онцолсон юм. Мөн 2014 онд "Алтан намар" хөгжмийн наадмаар 20 хоногийн дотор "Сүлдэт төрийн жавхаа" симфони марш, "Их хотын анир" хэмээх аккордионы гоцлолтой симфони хэмээх хоёр бүтээлийг туурвиж, өөрөө найраг баян хуураар гоцлон амжилттай оролцжээ.

Үүнийг тэрлэгч миний бие эрхэм гавьяатаас түүний онгод нь хэдийд, хэрхэн ордог тухайд сонирхон лавлахад, "Хүмүүс янз бүрийн байдалтай л онгод ордог гэж ярьдаг. Миний хувьд ямар ч үед онгод маань орж ирдэг. Амьдрал

жаахан саадтай үед, санаа сэтгэл тайван бус үед, аливаа нэг хүнтэй ам мурийсан үед, чимээ шуугиантай үед, онгоц, галт тэрэг, автобус, машинд гээд хэдийд ч, хаана ч хамаагүй уран бүтээлээ туурвидаг. Хаана ч, ямар ч нөхцөлд, сэтгэлд буусан шүлэг л байвал аялгуу нь шууд л ороод ирдэг. Энд нэг жишээ хэлэхэд хотын комендантад журамлагдах үедээ Л.Дандар баатарт зориулсан "Тамсагийн цэнхэр хязгаар" дуугаа бичиж явлага шүү дээ. Ер нь санамсаргүй бичсэн дуу их амилдаг, олон түмэнд таатай хүрдэг. Аливаа хүнээс шүлгийг нь аваад хонуулж үзээгүй дээ" хэмээн бардам хэлсэн.

### ГАВЬЯАТЫН УРАН БҮТЭЭЛ ЦААШИД Ч ӨРНӨНӨ

Г.Тэрбиш анх 1971 онд Ардын хувьсгалын 50 жилийн ойн баярын үеэр төрийн хүндэтгэлийн концертод Р.Хачатуряны хөгжим "Гаяней" бүжгийн жүжгийн "Сэлэмт бүжиг"-ийн хөгжмийг гоцлон хөгжимдөж, үзэгчдээс өндөр үнэлэлт авчээ. Энэхүү тоглолтын дараа тухайн үеийн төр, засгийн тэргүүн, маршал Ю.Цэдэнбал дарга чуулгын бүрэн бүрэлдэхүүний жагсаалын өмнө баяр хүргэж сайшаасан нь түүнд ихэд урам өгсөн гэдэг. Тэр цагаас хойш яруу найрагч Д.Лхагвасүрэнгийн шүлгээр "Эрэн нуур", Б.Лхагвасүрэнгийн шүлгээр "Тамсагийн цэнхэр хязгаар", Ш.Сүрэнжавын шүлгээр "Цэрэг хүний жавхаа" дан найрал дууг зохиож, Гавьяат жүжигчин Д.Лхамжавын дэглэлт "Морьт цэргийн бүжиг", "Цэнхэр дурдан алчуур", "Баярын өдөр", "Уран хээ" зэрэг хэд хэдэн бүжгийн хөгжмүүдийг зохиожээ. Мөн 1990-ээд оны эхээр симфони найрал хөгжмийн бүтээлд зориулсан "Гал голомт" симфони найраглалыг зохиосон ба энэхүү бүтээлээрээ тухайн үеийн хөгжим судлаач, шүүмжлэгчдээс сайшаал хүртэж явсан нь бахархалтай. Гоцлол хөгжимчин Г.Тэрбишид БНМАУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар 1990 онд Гавьяат жүжигчин хэмээх эрхэм хүндтэй цолыг хүртээсэн юм.

Тэрээр концертмейстр буюу гоцлон дуулаачдын багшаар олон жил ажилласан бөгөөд Ардын жүжигчин Ө.Баярмагнай, Гавьяат жүжигчин Г.Жанчив, Г.Батзориг, Д.Дорждэрэм, Д.Батсүх, Д.Батцэрэг, Соёлын тэргүүний ажилтан, дуучин Н.Эрдэнэбаяр, Ж.Баатарсүрэн, Д.Жаргалсайхан нар түүнийг багш аа хэмээн ихэд хүндэтгэх юм билээ.

Гавьяат жүжигчин Г.Тэрбиш 26 жил хөдөлмөрлөөд ид хийж бүтээх насандаа гавьяаныхаа амралтад гарсан ажээ. Тэр үед эхэндээ тун хэцүү санагдавч, өөрөө гоцлол хөгжимчин байсан болохоор ганцаардахын зовлонг огт үзээгүй гэдэг. Тэр бээр өдгөө чуулгынхаа залуу уран бүтээлчидтэй байнга хамтдаа байж, "Хан эгшиг" төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулагчдын нэг нь хэмээгдэж, чуулгынхаа уран бүтээлчдийн хөгжилд багагүй хувь нэмэр оруулж буйгаараа ихэд бахархдаг гэсэн чин сэтгэлийнхээ үгийг дайсан юм. Эрхэм гавьяат маань шинэ оны босгон дээр ЦДБЭЧ-ын Сургалт, соёл хүмүүжил, маркетингийн албаны дарга, Соёлын тэргүүний ажилтан, хошууч Р.Өнөржаргалын шүлгээр "Холдож нүүгээгүй сэтгэл минь", "Нутагтаа би очно" дууг өлгийдөн авчээ. Тэрчлэн энэ оны шилдэг дуу шалгаруулах "Морин хуур" наадамд өөрийн бүтээлүүдээрээ оролцохоор бэлтгэж байна.

Түүний уран бүтээл цаашид ч үргэлжилнэ ээ ...

**Хурандаа Б.ОТГОНБЯАР**

Монгол түмний уламжлалт сар шинийн баяр гадаад улсад үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багуудын хувьд Монгол Улсаа сурталчлах, үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ болж өнгөрдөг. ИБНАУ-д явагдаж буй цэрийн багуудын бие бүрэлдэхүүний төлөөллийн сар шинийн баяртай холбоотой дурсамжийг хүргэж байна.

## Д.Баяртогтох: ХҮҮХЭД НАСНЫ ДУРСАМЖУУД СЭТГЭЛД ХАМГИЙН ТОД

ИБНАУ-д явагдаж буй “НАТО”-ийн цэргийн хүчний тэргүүлсэн “Шийдвэртэй дэмжлэг” олон улсын ажиллагаанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн хамгаалалтын ротын Х ээлжийн Цэргийн багийн салааны захирагч, ахлах дэслэгч **Д.БАЯРТОГТОХ** (Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн захирагчийн орлогч, дэд хурандаа):



айл хэснэ, мэдээж бэлэг авахын төлөө л явж байгаа хэрэг шүү дээ. Тэднийх том бэлэг өгдөг, тэднийх бага бэлэг өгдөг гэх жишээний юм яриад л хэсдэг байсан даа. Үндэсний маань том өв уламжлал, ёс заншил шингэсэн баяр учир гэр бүлийн хамт өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлдэг. Аав, ээждээ золгох, ахмад настнуудаа хүндэтгэх, бага балчрыг энэрэх нь бидний эрхэм үүрэг. Харин энэ удаад бол хилийн чанадад, ажиллагааны газар оронд сар шинийн баярыг угтах гэж байна. Манай цэргийн багийн бүрэлдэхүүн харьцангуй залуу учраас цэргийн албаас гадна монгол ёс заншил, өв уламжил гээд зааж зааварлан, туршлага, сургамжаасаа хуваалцаж байна. Мөн багийнхаа залуучуудаас ч их зүйл суралцаж байна.

Энэ дашрамд Төв аймгийн Эрдэнэ суманд амьдарч байгаа хайрт аав, ээж, дүү нартаа болон гэр бүлийнхэндээ мөн Зэвсэгт хүчинд залуу насаа зориулсан ахмадууд, нийт бие бүрэлдэхүүн болон цэргийн багийн хамт олондоо сар шинийн мэндийг дэвшүүлж, төрлөөрөө түвшин амгалан, элгээрээ энх амгалан байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлэе.

-Би Төв аймгийн Эрдэнэ сумын унаган хүүхэд. Бага насаа хөдөө сумандаа өнгөрөөсөн учир хүүхэд насны цагаан сарын дурсамжууд л сэтгэлд хамгийн тод байна. Бага байхад ангийнхаа хүүхдүүдтэй нийлж

## Б.Товуудорж: МАРТАГДАХААРГҮЙ ЦАГААН САР ЭНЭ ЖИЛ ТОХИОЖ БАЙНА

ИБНАУ-д явагдаж буй “Шийдвэртэй дэмжлэг” олон улсын ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн хамгаалалтын ротын XI ээлжийн Цэргийн багийн дэд ахлагч **Б.ТОВУУДОРЖ** (Зэвсэгт хүчний 110 дугаар анги):

-Мартагдахааргүй цагаан сар 2020 оны хулгана жил тохиож байна. Яагаад гэвэл миний хувьд анхны гэх тодотголтой зүйлс маш олон байна. Цэргийн хүн болж эх дэлхийн энх тайвны үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулан алс холын Афганистан улсад олон үндэсний цэргүүдтэй мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэж байгаагаа энэ дашрамд онцлох нь зүйтэй болов уу. Ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж байх хугацаанд гэргий О.Цэгмэд минь амаржиж 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдөр удам залгах хүүтэй болж аав хэмээх эрхэм алдрын эзэн болсон торгон мэдрэмж хамгийн сайхан байлаа. Монгол түмний минь ёс заншил болсон сар шинийн баярыг харийн оронд үүрэг гүйцэтгэж байх үедээ цэргийн багийн хамт олонтойгоо тэмдэглэн өнгөрүүлэх мөч хэзээ ч мартахааргүй дурсамж болон үлдэх болно. Үүнээс гадна эх орноо ямар тайван, эрх чөлөөт, байгалийн цогц бүрдсэн үзэсгэлэнт газар нутаг, өв уламжлалт ёс заншилтай, сайхан юм бэ гэдгийг харь орны газар оронд үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа биеэр мэдэрч, ухамсарлаж байна. Сар шинийн баяраар Хөвсгөл аймгийн Мөрөн, Цэцэрлэг сум руу гэр бүлийн хамт очиж өвөө, эмээ, аав, ээж, ах, эгч нарынхаа гэрээр зочилж, амар мэндийг нь эрж, өргөн тэмдэглэдэг. Зарим үед бүтэн жил уулзаагүй ах, дүүстэйгээ хууч хөөрөн, тухайн жилийн



болон бусад сонирхолтой зүйлсийн талаар ярьж явахад цаг маш хурдан өнгөрдөг шүү. Аав, ээж, хань, хүү, ах, дүү, цэргийн багийн хамт олондоо болон Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн бие бүрэлдэхүүндээ XVII жарны “Хотол төгс” хэмээгч төмөр хулгана жилийн сар шинийн баярын мэндийг дэвшүүлэе. Монгол түмэн минь сайхан шинэлээрэй.

### УРАН БҮТЭЭЛЧ

“Хурд” хамтлагийн гитарчин, МУГЖ Д.ОТГОНБАЯР

Сүүлийн үед ямар уран бүтээл туурвиж байгаа талаар тань ярилцлагынхаа эхэнд сонирхмоор байна...

-Уран бүтээл ёстой ундарч байна. “The Voice of Mongolia” шоуны шүүгч, дасгалжуулагчаар ажиллаж байгаа учраас өөрийн багийн залуу дуучдын уран бүтээл дээр ажиллаж, шинэ соргог уран бүтээлээр үзэгч, сонсогчдынхоо сонорыг мялаах гэж хичээж байна. Мэдээж шоу нэвтрүүлгийн хажуугаар миний амьдралын салшгүй нэг хэсэг болсон “Хурд” хамтлагийн уран бүтээлийн ажилд эрчимтэй орсон. Жишээлбэл, “7 тэрбум” нэртэй пьез, CD-г хэвлүүлэхээр Москва хот руу явуулсан. Анх 1994 онд Монгол



## Д.Отгонбаяр: "ЦЭРГИЙН БОДОЛ" ХУЖИРБУЛАНД ТӨРСӨН ТҮҮХТЭЙ

Улсад “Хеви-Метал” хэмээх урсгал гаргаж байсантай холбоотой, тийм өнгө аястай бүтээлүүд багтсан. CD, пьез гэсэн хоёр хувилбараар гаргаж байгаа нь сонсогчдоо онцгой сэтгэгдэл төрүүлнэ гэж найдаж байна. Мөн цомгоос онцлох зүйл гэвэл хамтлагийн гишүүн бүр дуу зохиож, цомогтоо оруулсан нь шинэлэг зүйл болсон. Бас “The Voice of Mongolia” шоуны шүүгч, дасгалжуулагч Ука “7 тэрбум” хэмээх уран бүтээл дээр бидэнтэй хамтарч ажилласан гэдгийг хэлэхэд таатай байна.

**Цэргийн албаны тухай Та ямар бодолтой байдаг вэ?**

-Эр хүний хамгийн том бахархал эр цэргийн алба, эх орноо хамгаалах явдал юм. Эрдэнэт хүн болж орчлонд мэндэлнэ гэдэг нэгт тавагдах их хувь заяа. Эх орноо хамгаалж эр цэргийн алба хаах нь хоёр дахь хувь заяа. Аз жаргалтай гэр бүлийг цогцлоон байгуулж, аав, ээж, эмээ, өвөө шигээ амьдралаа авч явах нь эр хүний гурав дахь хувь заяа. Бусад нь болно доо. Амьдарч л байгаа хойно унаж, босно. Гудайж, гутарч явж болохгүй, эр хүн. Мэдээж амьдралд ёс бус үйл хэрэг, муу зуршил, найз нөхөд таарна. Эр хүн бүгдийг тунгаан бодож туулах хэрэг гарна. Эх орноо хамгаалж, эр цэргийн алба хаах нь эр хүн болсны хамгийн том алдар гавьяа. Эх орноо хайрлах нь маш том үнэ цэн, бахархал, юугаар ч сольшгүй итгэл, насан туршид нь хадгалагдаж үлдэх үүрэг, хариуцлага. Учир иймд эр хүн болгон цэрэгт явах ёстой гэж би боддог.

**Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид дэлхий дахины халуун цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байна. Энхийг сахиулагчдын талаар Та юу хэлэх вэ?**

-Бас л том бахархал. Бид нэг

наран дор, нэг агаараар амьсгалж байна гэдэг нь бид нэг гэр бүл гэсэн үг. Энэ олон улс хилээр зааглагдаж байгаа боловч энэ дэлхий маш жижигхэн шүү дээ. Монгол Улсын Зэвсэгт хүчнээс энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаад иргэн хүний хувьд ихэд баяртай явдаг. Энхийг сахиулж байгаа залуучуудыг би үндэсний баатар гэж нэрлэнэ.

**“Цэргийн бодол” дуу бол цэргийнхний төдийгүй ард түмний хайртай уран бүтээл юм. Хэрхэн бүтэж байсан талаар дурсахгүй юу?**

-Манай хамгийн том ах Д.Ганболд Хужирбулангийн ангид ахлах түрүүч цолтой алба хааж байсан юм. Тэр бээр 1978 онд халагдах цэрэг байхдаа өөрийн хайртай бүсгүйд зориулан энэхүү дууг зохиосон. Энэ дуу бол эгэл жирийн хайр сэтгэлээс ундарч гарсан уран бүтээл юм. Үе үеэрээ энэ дуунд хайртай байдаг нь тийм л учиртай байх. Цэргийн хуаран бүрээс эгшиглэж байдаг дуу гэж хэлэхэд хилсдэхгүй биз. Байлдагч нар хамтарч шүлгийг нь бичээд манай ах редакторласан гэдэг. Тэгээд 1993 онд “Хурд” хамтлаг байгуулагдахад ах маань “Миний энэ дууг дуулаач” гэж надаас их гуйдаг байсан. Харин би гэдэг хүн улаан метал рок байсан учир “Ийм уянгын дуу дуулахгүй” гээд л их зөрдөг байж билээ. Тэр үед Д.Ганбаяр ах маань “Энэ дууг Монголын ард түмэн тосоод авах юм бол манай хамтлагийн цаашдын бүтээлүүдийг өлгөйдөж авах булган сүүлтэй дуу болж магадгүй” гэж хэлснийг нь бид бүхэн зөвшөөрч дуулсан түүхтэй.

**Хурд хамтлагийн гишүүдээс хэд нь цэргийн алба хаасан бэ?**

-Цэргийн алба хаж байгаа ах нарыгаа л эргэж очиж байсан

болохоос биш би өөрөө цэргийн алба хаагаагүй. Бид эцэг, эхээс 11-үүлээ, 10хүү, нэг охинтой айл. Тэднээс долоо нь цэргийн алба хаасан. Би Монгол Улсаа магтсан дуунуудыг зохиож дуулаад хамтлагийнхантайгаа хамт энэ насаараа л цэргийн алба хааж явна даа.

**Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын дуучин ахлагч А.Болормаа анхны “Voice”-д танай багт орж байсан. Цэргийн хүний давуу тал танд ажиглагдаж байсан уу?**

-Анх А.Болормааг багтаа авч байхдаа маш их баярласан. А.Болормаатай ажиллахад үнэхээр амар, тэсвэртэй, цагаа яс барина. Урлагийн бид нар хоолоо умартаж ажилладаг шүү дээ. Яг л надтай хамт уран бүтээл дээр ажиллаж, шүдээ зуугаад л ард нь гардаг. Миний хагас цэрэгжилтийн зохион байгуулалт, удирдлага доор нийцэж ажилласан. Анхны шоу дээр үнэхээр гайхамшигтай бүтээлүүдийг хамт дуулж, эх орны төлөө хэмээх миний бүтээлүүдийг маш гоё хувилбараар ард түмэндээ сонгож байсан. Энэ шоу чимж чадсан уран бүтээлч бөгөөд эцсийн шалгаруулалтад үлдэж хоёрдугаар байрыг эзэлнэ гэдэг маш том амжилт. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, ЦДБЭЧ-ын хамт олон, хамтарч ажилласан бүх хүмүүсийн үйл хэрэг үүнд хамаатай. Нэгдсэн зохион байгуулалт гэж үүнийг л хэлэх байх.

Энэ дашрамд хэлэхэд би Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойд зориулан хоёр дуу зохиосон. Тэр дуугаа Цэргийн дуу бүжгийн чуулгын хамт олонтой хамтарч дуулах хүсэлтэй байгаа. Цаашид ч олон чиглэлээр хамтарч ажиллах болно.

## МАЛЧИН УДАМТ “МАЛЫН” Г.ЯДМАА

“Гэндэн”-гийн гэхээсээ “малын” Ядмаа хэмээн түмэн олондоо ажил, мэргэжлээрээ овоглогдсон энэ эрхмийг Зэвсэгт хүчний нэгэн үеийнхэн андахгүй. Увс аймгийн Малчин суманд малчин Гэндэнгийн ууган хүү болон мэндэлсэн тэрээр малын эмч мэргэжилтэй. Эзэмшсэн мэргэжил, эрхэлсэн ажил нь түүний бахархал. Чөлөөнд байгаа дэд хурандаа Г.Ядмаа идэр залуу наснаасаа өтөл буурал болтлоо Зэвсэгт хүчинд 27 жил офицерын албан тушаалд ажилласан ахмад дайчин. Гавьяаныхаа амралтад гарснаас хойш ч Зэвсэгт хүчний 310, 232 дугаар ангиудад хөдөө аж ахуйн мэргэжлийн туршлага, мэдлэг, чадвараа зориулан 10 гаруй жил ажилласан энэ хүний ажил, амьдралын түүх баялаг, намтар арвин. Түүнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр Зэвсэгт хүчний хэмжээнд очоогүй анги, салбар, хүрээгүй газар, хийгээгүй ажил нэн ховор. Бидний нэрлэж заншсан “хэрийн академи” буюу Ардын Армийн 126 дугаар ангиас ажлын гараагаа эхэлж Мал эмнэлгийн албаны даргаар найман жил ажиллаад Армийн мал эмнэлгийн Бактериологийн лабораторид малын их эмчээр томилогдсон. Энэ хугацаанд малын өвчлөлийн суурь судалгаа шинжилгээ хийх, малыг элдэв



Зүүн гар талаас хоёр дахь нь дэд хурандаа Г.Ядмаа. Зэвсэгт хүчний ангиудад ургацын баланс тогтоох ажлын үеэр хэсэг нөхдийн хамт. 1985 он

празит, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын өвчнийг оношилж эмчлэх, малын эм тариа, бэлдмэлээр нөхөн хангах ажлыг мэргэжлийн өндөр түвшинд хийж чадсан малын эмч гэдгийг үнэлэх хүн олон. Армийн мал команд (Зэвсэгт хүчний 232 дугаар анги)-ын даргаар 1980-1981 онд ажиллаж байв. Мал командын удирдлага, малчин дайчид 3 гэрт төвлөрч, өөрийн мэдлийн өвөлжөө, хашаа саравч, бэлчээр, өвс, тэжээл хомс байсан хүнд үе. 1981 оны хаврын зүүн бүсийн аймгуудыг хамарсан байгалийн гэнэтийн үзэгдэл хүчтэй цасан шуургатай нүүр тулж, хариуцсан мал сүргээ хохирол багатай авч гарсан гэдэг. Ардын Армийн Ар талыг удирдах газарт ажиллаж байсан он жилүүдэд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлогыг тодорхойлолцож, ойрын болон хэтийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг нь зохион байгуулахад Зэвсэгт хүчний ангиудын хөдөө аж ахуйн мэргэжилтэн, туслах аж ахуйн дарга, малчид, тариаланчдыг түүчээлэн явж үнэнч сэтгэл, мятаршгүй зүтгэлээр ажиллаж байсан үе нь өнөөдөр түүх болон үлджээ.

Чөлөөнд байгаа дэд хурандаа Г.Ядмаа нь Зэвсэгт хүчний мал, мах бэлтгэл, урсгал болон өвлийн их нядалгаа, хаврын тариалалт, намрын ургац хураалтад олон жил биечлэн оролцсон юм. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эхлэл төгсгөлгүй, дуусаж дундардаггүй нөр их ажилд хаврын жижүүн хавсарга, зуны аагим халуун, намрын сэрүүн хяруу, өвлийн тэсгим хүйтэнд ч өвдөг сөхөрч, зориг шантарч, итгэл алдаагүй нэгэн. Зэвсэгт хүчний ангиудын хэрэгцээт төмс, хүнсний ногооны нэлээд хэсгийг бэлтгэн нийлүүлдэг байсан Зэвсэгт хүчний 072 дугаар ангийн тариалантын талбай, одоо хүртэл Зэвсэгт хүний офицер, ахлагч, ажилчин албан хаагч, ахмад дайчдын нийгмийн асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэхэд дэмжлэг болж байгаа Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн харьяа Баруун хараа дахь эрчимжсэн аж ахуй, Налайх дахь “Найман шарга” амралт, сувиллын газрын эхний шанг таталцсан хүний нэг.

Г.Ядмаа буянт малынхаа бэлчээрийг бүтэн тойрч, атар газрынхаа ариун хөрснөөс атгаж үзсэн, хал үзэж хат суусан хөдөө аж ахуйн чадварлаг мэргэшсэн мэргэжилтэн юм. Хөөрөг зөрүүлж, цай уух зууртаа л өтгөс буурлуудтай ч, өсвөр залуучуудтай ч дотно бөгөөд энгийн яриа үүсгэж, өөрийгөө бусдад таниулж, залууст туршлага, сургамжаа хайрлаж чаддаг нь бас л нэг бахархам чанар. Энгийн сэтгэл татам яриа, инээдэмтэй хошигнолоороо уулзсан бүхэндээ инээд бэлэглэж, өөрийн тэрлэсэн шүлгээсээ уншин биднээсээ “их найрагч” хэмээх цолоор өргөмжлөгдсөн гавьяатан билээ. Ой санамждаа маш ихийг хурааж, ажил, амьдралын асар их туршлага хуримтлуулж, амьдралын хөлгөн судрыг уншиж нэвтэрхий толь мэт болсон энэ хүний ухаан далайгаас хишиг хүртэж яваа нь залуу үеийнхний бас л нэг завшаан.

Энэхүү настан буурлын аяны дөрөө нь сүүгээр мялаалгаастай, амьдралын зам нь алтан шаргал тариан талбайн өнгөөр гэрэлтэж яваа буянтан. Хилэнц нэмж, буян хомслох аливаа тохиолдлоос алс хол байж тэнгэрлэг итгэлээр жигүүрлэн урагш тэмүүлдэг жирийн монгол эр хүн.

Үйлчилгээний гавьяат ажилтан, бэлтгэл дэд хурандаа **Ч.ДАШДЭЛЭГ**

АХМАД ҮЕ



Домог мэт амьдарч буй "элэгний" гэх тодотголтой чөлөөнд байгаа хурандаа Жамцын Жамсрантай уулзаж ярилцлаа. Ам цагаан хулгана жилийн босгон дээр 97 насны сүүдэр тохиож буй Батлан хамгаалах салбарын хамгийн өндөр настай буурлуудын нэгний үг, сургаалыг сонсох нь учир бэлгэдэлтэй бас гүн хүндэтгэлтэй юм. Тэрээр хуучнаар "Мэргэжилтний хорь", өнөөгийн "Голомт" банкны зүүн талд орших хуучны дөрвөн давхар тоосгон байшинд энх тунх аж төрөн сууна.

Хэдэн жилийн өмнө уншигчдынхаа захиа даалгавраар зорин очиж байсан болохоор "Тататунгаа"-г үйгээр шууд л хаалганыг нь хонхыг дарлаа. Өвгөн ч харуулын цэрэг шиг бэлэн, тэвхэлтэл ирж онгойлгов. Гучин гурван жил тутамд нэг нас нэмж тооцдог лам нарын тооллоор авч үзвэл буурал хурандаа маань өдгөө 100 насны босго давж яваа ажээ.

#### ХААН ХАЛЬЖ, ХҮҮ МЭНДЛЭВ

Ж.Жамсран хурандаа 1923 онд буюу Монголын сүүлчийн эзэн хаан Богд Живзундамба хутагтын сүүдэр хальсан жил Хан Хэнтий уулын аймгийн ард Жамцын гурван хүүгийн отгон нь болж төржээ. "Багадаа их л сэргэлэн, цовоо хүүхэд

зураад өгөөч" гээд дахин ёслол. Ю.Цэдэнбал "Яасан сүрхий хүүхэд вэ" гэхлээр нь дахиад л ёсолж "Энэ бол хариуцлага" гэж хэлжээ. Дарга "Чи ямар хариуцлагатай хүүхэд вэ. Сурах ёстой хүн байна" гэж хэлэв. Сурах ёстой гэдэг үнэ цэнтэй үг байлаа гэж тэрээр дурсан өгүүлсэн.

Сурах чиглэлийг эрхэм болгох зөвлөгөөг тэрээр үүрэг гэж ойлгож Намын шинэ хүчний сургууль буюу Намын дээд сургуульд элсэх зорилгыг өөртөө тавьсан байна. Дөнгөж 19 нас хүрч байдаг. Тухайн үеийн хамгийн нэр хүндтэй энэ сургуульд 25 нас хүрч байж элсэх ёстой гэх. Сэргэлэн залууд Сүхбаатар жанжны гэргий Янжмаа гуайтай уулзах санаа төрөв. Сураглаж яваад уулзлаа. Тэрээр миний эрхлэх ажил биш байна гээд халгаах шинжгүй. Ж.Жамсран өөрийн эрхгүй эхэр татан уйлав. Янжмаа гуай юу болов гэж асуулаа. Таныг хараад ээжийгээ саналаа гэж хэлсэнээ санаж байна. Залуу хүний чин хүслийг ойлгосон байх. Сургуульд ороход чинь тусална гэж амлажээ.

Ингээд Намын дээд сургуульд 19 настайдаа элссэн цорын ганц хүн болсон гэнэ. Том хүний итгэлийг биелүүлж сайн ч суралцсан байна. Өсөх ирээдүйтэй залуухан дарга Монголын хувьсгалт залуучуудын эвлэлийн Төв хороонд нарийн бичгийн дарга хүртэлх алба хааж, галзуу барын аманд гараа хийхээс буцахгүй явсан үе түүнд бий.

# ДОМОГ МЭТ

## АМЬДРАЛ

байсан гэж аав, ээж маань ярьдаг байв. Ямар сайндаа ах нараа шоглосон хэрэгт орж, аавын суран бусний амтыг цөөнгүй үзэж өссөн гэдэг" хэмээн буурал хурандаа хууч дэлгэлээ.

Долоон настайдаа тэр цагийн хурал номын томоохон газар байсан Хэрлэнгийн хүрээнд шавилан суужээ. Багш нь хошуу нутагтаа нэр алдар нь түгсэн оточ маарамба Сэрээтэр гэх лам байв. Тангад ном цээжилж, эмийн цаас зүсэн, эм тан найруулах зэрэг ажилд туслан хэдэн жил боллоо. Багшийнхаа сургаж хэлж байснаас "Ээ дээ, хүүхдүүд минь ус, цус хоёрт уулын хааны (Баавгай) цус тун сайн шүү" гэж хэлсэн үгийг өдгөө ч санаж явдаг гэсэн.

Ардын сургууль байгуулагдаж, шинэ цагийн соёл нэвтрэх цагаар Ж.Жамсран сургуулийн сурагч болов. Онцсайн суралцаж, сургуулийн Сурагчдын зөвлөлийн даргаар сонгогдон гялалзаж гарлаа. Нэгэн өдөр сургуулийн гадаа гялтганасан хар өнгийн "чийчаан" машин ирж зогсов. Сурлага, хүмүүжлээр сургуульдаа толгой цохиж яваа Жамсран гүйн очиж сурагчдын амжилт ололтыг дуржигнатал илтгэлээ. Нөгөө том дарга "Мундаг хүү байна. Цэргийн дарга болоорой" гэж хэлэв. Тэр эрхэм бол БНМАУ-ын гарамгай баатар Лодонгийн Дандар байлаа. Хожим нь баатар маань Ж.Жамсран гуайд илтгэл өгсөн сонин тохиолдол бий ажээ.

#### ЭНЭ БОЛ ХАРИУЦЛАГА

Хан Хэнтийд төрсөн хүү 17 настайдаа Улаанбаатарт ирж төрийн алба хаших болов. Дотоод яамны үүдэнд хянагчаар ажиллалаа. Энэ үед Ю.Цэдэнбал даргад таалагдсан нэгэн тохиолдол болжээ. Сайд Б.Шагдаржав гаднаас орж ирээд Ю.Цэдэнбал даргад хүлээлгэж өг гээд жижиг бичгийг түүнд өгсөн байна. Сангийн яамны сайдаар ажиллаж байгаад Намын Төв Хорооны нарийн бичгийн даргаар дэвшсэн залуухан дарга Сангийн яамны дээд давхарт байрлаж байв. Хаалгыг нь зөөлхөн тогшиж ороод "Нөхөр даргад болох уу, Сайдын бичиг авчирлаа" гэж илтгэлээ. Дарга бичгийг авч "За явж болно оо" гэв. Жамсран "Нөхөр даргад гарын үсгээ

#### "СРАЗУ МАЙОР" ГЭДЭГ ШИГ

Жамсран гуайн цэрэг армитай холбогдсон түүх сонин. Дорнод аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар ажиллаж байхад нь Ю.Цэдэнбал дарга дуудуулжээ. Ямар нэг алдаа гаргасан юм болов уу гэж эмзээнгүй орсон аж. Гэтэл огт санаанд ороогүй ажлыг санал болгосон байна. Ардын Армийн Улс төрийн газрын нэгдүгээр орлогч даргаар ажиллуулах юм гэнэ. Ардын Армийн 50 жилийн ой болох гээд ажил ихтэй байжээ. Тавин жилийн ойн түүхийн цомог бүтээх ажил дээр хамтарч ажиллах шаардлага байгаа тухай Ю.Цэдэнбал дарга тайлбарласан аж.

Татгалзах эрх байсангүй. "Сразу майор" гэдэг шиг л шууд хурандаа цол олгов. Том албан тушаал дээр ахмад, хошууч цол зүүж очиж болохгүй байлаа. "Монголын Ардын Арми 50 жил" гэсэн ногоон хавтастай цомог дээр ёстой л шим шүүсээ шавхтал ажиллажээ. Ховор нандин гэрэл зургууд олон оржээ. Ялангуяа Зөвлөлтийн цэргийн дарга нарын нэр, овгийг Бал дарга гарамгай мэддэг, бас нэг ийм зураг байх учиртай гэж архивуудаар хайлгадаг байж. Түүхэн үйл явдлын гэрчүүд амьд сэрүүн байсан болохоор хувь хүмүүсийн гар дээрээс ч түүхэн зургууд олон цугларчээ. Орчин үеийн цэрэг армийн түүхийг өгүүлсэн чухал цомог бүтээсэндээ Ж.Жамсран гуай өдгөө сэтгэл ханамжтай байна. Мөнөөх сэргэлэн зангаар БНАГУ-д үнэгүй хэвлүүлж амжсан гэж байгаа. Өнөөдөр энэ цомог бараг харагдахаа больж сүүлийн үеийнхэн ийм цомог байдаг гэдгийг мэдэхгүй гэж хариулах болсонд харамсаж суудага буурал хурандаа өгүүлэв.

Цэрэг армид хөлөө олж, ид хийж бүтээх ажлынхаа амтанд орж явтал хэлж ирэхгүй хийсэж ирсэн өвчин тусжээ. Магадгүй өөрийг нь сорих гэсэн амьдралын шалгалт байсан байж болно. Ямар ч байсан тэрээр нэгэн гайхамшигт бүтээсэн юм.

#### ХООСОН БУУ ХОРИН ЖИЛД НЭГ ДУУГАРДАГ

ЗХУ-д сургалтад очиж номын дуу сонсож явтал бие нь чилээрхээд болдоггүй. Эмч нарт үзүүлэлт элэгний өвчин хүнд

үедээ орсон гэсэн онош гарчээ. Орос эмч нарын зөвлөгөөгөөр Болгар улс руу эмчилгээнд явав. Бас эдгээж чаддаггүй. Сүүлд нь Германд гурван жил боллоо. Бас л эмчлэгдсэнгүй. "Соц" системийн оргил болсон орнуудын анагаах ухаан дийлсэнгүй. Эмчилгээгүй гэсэн оноштой эх орондоо ирлээ. Сайд нарын 2 дугаар эмнэлэгт хэвтэж байтал, нэг шөнө төрсөн нутаг нь зүүдлэгдэж, хүрээд ир гээд даллаад болдоггүй.

Зөн совиндоо бат итгэсэн Ж.Жамсран нутаг явах хүсэлтээ Ю.Цэдэнбал даргад илэрхийлэв. Дарга "Жамсран минь явдал гүйцэх болов уу даа. Нисдэг тэрэг гаргаж өгье" гэсэн байна. Ингээд Төв аймгийн Мөнгөнморьт суманд хүн зөөврийн "носилк"-тай газардав. Арми түүнд туслах хүн хүч, гэр орон бэлтгэж өгчээ.

Нутагтаа ирлээ гэж бодохоор нулимс аяндаа асгараад л. Хангай дэлхийгээ, цэнгэг ус, цэцэг ногоог хараад сэтгэл сэргэх шиг болов. Ингээд өөрийгөө эмчлэхээр сэтгэл шулуудсан байна. Шууд л Хэрлэн голынхоо усыг ууж, өвс ургамал идэж, цэвэр агаараар амьсгалж эхэлсэн чинь бие нь мэдэгдэхүйц сайжраад ирэв. Тэгэхээр нь ой модоор гэр хийж нэг хэсэг амьдарсан. Хүнд дараа болохгүй гээд нэг морь, нохой дагуулаад уул руу гараад өгөв. Сумын төвөөс цааш явсаар Бурхан Халдун ууланд хүрч зэрлэгшсэн хүн боллоо.

Бал дарга цаадхынхаа сэтгэлийг засаад ир гээд Улсын Бага хурлын дарга С.Лувсанг илгээжээ. Хийморийг тань сэргээж Бурхан Халдун уулын оргил дээр гарна гэв. Босгын даваа хүртэл машинаар яваад цаашаа мориор явж Бурхан Халдуны орой дээр гарлаа. С.Лувсан гуайг Чехэд элчин сайд байхад винтов буу дурсгажээ. Түүгээрээ нэг ёслол хийдэг юм билүү гээд гох дартал бууддаггүй. "Өө, үйлдвэрийн гологдол байж л дээ" гээд буугаа үүрчээ. Уулнаас буух боллоо. Газарчилж явсан нутгийн хоёр хүн дорхноо л буугаад явчихлаа. Хоёр дарга эмээлийнхээ араар суугаад уруудаж явтал унаж явсан морь нь үргэх шиг болж.

Жолоогоо татаад хартал зүүн талаас нэг баавгай гараад иржээ. Жамсран "Даргаа харж байна уу" гээд шивнэтэл "Харж байна" гээд буугаа мөрнөөсөө аваад шагайж байна. Дуугарахгүй буугаар яах нь вэ

дээ гэж бодож байсан гэдэг. Уг нь баавгайн цөс идвэл түүнд эмчилгээ болох байсан юм. Гэтэл буу ч тасхийж, баавгай ч ойчлоо.

Бурхан Халдун уул ухаантай, эзэн Чингис тэнд нойрсож байгаа. Тиймээс харц ардыгаа аврах үүднээс таны буг уулын оройд биш энд дуугаргаж байгаа юм гэж С.Лувсан гуайд хэлсэн гэдэг. Жамсран баавгайн цөс ууснаар үе үе бөөлжөөд байсан нь тогтсон байна. Дараа нь өөрөө өөртөө жор гаргаж ууж эхэлсэн аж. Тэр баавгайныхаа саврыг өдгөө ханандаа өлгөчөөд л шүтэж байдаг гэж сонирхуулсан юм.

Ийнхүү "Зэрлэг хурандаа" хэмээн хочлогдох болсон эл буурлын амьдралын нандин сайхан түүхийг сонсож суухад эрт урьдын домог хүүрнэх мэт санагдсан. Түүний амьдрал тэр чигээрээ домог, түүх юм.

#### ТҮҮХЭН ХҮМҮҮСТЭЙ ҮҮЛЭСАН ХОВОР АГШИН

Ж.Жамсран гуайн Германд хэвтэж байсан эмнэлэгт нь хожим манай нэгэн том дарга очиж хэвтжээ. Эмч нар "Хурандаа Жамсран хэдийд бурхан болсон бэ" гэж асуугаад "Тэр хүн чинь амьд сэрүүн, буу шийдэм үүрээд уул хадаар зугаалж байгаа" гэсэн хариу сонсоод итгэж өгөхгүй гайхаацаж байсан гэдэг.

Дэлхийн сансрын хөлгийг зохион бүтээсэн агуу эрхэм А.К.Королёв, сансрын анхны нисэгч Ю.Гагарин нартай уулзаж гар барьсан, Халхын голын дайны талбараас тодорсон нэрт сэтгүүлч К.Симоновын гарын үсгийг авч үлдсэн, Өмнөд хөршийн түүхэн их удирдагч Мао Цзэдуны хүлээн авалтад уригдаж могойн мах идсэн гээд хүн төрөлхтний түүхэнд нэр, мөрөө мөнхөлсөн олон алдартнуудтай нүүр тулан уулзсан хүн.

Дандар баатар түүнд ёсолсон сонинг Ж.Жамсран гуай хүмүүст хуучлах дуртай. Ардын Армийн Улс төрийн газрын нэгдүгээр орлогч дарга жигтэйхэн том өрөөнд бичиг цаас шагайн сууж байтал хэн нэгэн хаалга тогшиж орж ирээд сүртэй нь аргагүй илтгэл өгч байна гэнэ. Хийж буй зүйлээ

хойш тавиад харваас хүүхэд ахуйдаа ёслол гүйж байсан гарамгай баатар Лодонгийн Дандар эргээд өөрт нь ёслол зогсож байх нь тэр. Цэргийн дарга болоорой гэсэн баатрын захиасыг биелүүлж, олон жилийн дараа ингэж уулзсан байна.

#### ТӨГСГӨЛД НЬ ӨГҮҮЛЭХЭД...

Ж.Жамсран гуай амийг нь авч одох шахсан элэг гэдэг эрхтний талаар маш сайн мэдлэгтэй болжээ. Элэг өөх тос солилцооны чухал эрхтэн. Тийм учраас цөс ялгаруулж, хоол боловсруулан шингээхэд шууд оролцдог. Түүнчлэн өөх, өөхний хүчил, холестерин зэрэг бодис үүсгэхэд гол үүрэгтэй. Элэг нь цөсийг ялгаруулдаг. Цөсийг хуримтлуулагч эрхтэн нь цөсний уут болно. Тэрээр сунаж, агших чадвартай. Элэг нь гаднаас биед нэвтрэх элдэв бодисыг шүүж, цэвэршүүлэх үүрэгтэй гэх зэргээр бүхэл бүтэн лекц унших хэмжээний мэдлэг хуримтлуулжээ.

Тэрээр тан барьдаг өвөрмөц мэргэжлийг өөрийн амьдралаас сурч эзэмшсэн байна. Түүний бэлтгэсэн танг ууж хэрэглээд өвчин эмгэгээсээ салсан хүн цөөнгүй байдаг гэнэ. Жишээ нь Их тан буюу "Танчин-25" тангаа өөрийн аргаар намрын зэрлэг гахайн цусаар хүчжүүлэн бэлдсэн аж. Бас "Гарьд-5" гэдэг тан байна. Үүнийг нь Чингэлтэй дүүргийн иргэн Цэрэндорж гуай хэрэглээд хавдраас ангижирсан ажээ. Энэ мэт жишээ олныг дурдаж болох юм.

Хүмүүст хэрэгтэй болов уу гэж бодоод хэд хэдэн ном бичсэн байна. Эдгээр номд өөрийн өвчний түүх, түүнийг хэрхэн, ямар арга замаар илаарьшуулсан тухай тодорхой бичжээ. Элэгний өвчинд шиналсан олон хүн хөдөө гадаанаас түүнийг зорин ирж, зөвлөгөө авах болсон тул хүн ардад хэрэг болох үүднээс энэ номуудыг бичсэн гэж ярьсан. Түүний ном эрэлт хэрэгцээтэй, хэвлэлтээс гарсан даруйдаа уншигчдын хүртээл болдог ажээ.

Чөлөөнд байгаа хурандаа Ж.Жамсран гуайдаа зуу насалж зургаандай таяг тулахын элзийтэй ерөөлийг өргөө.

**Бэлтгэл хурандаа Г.НЯМДОРЖ**

# Г.Жаргалсайхан: ДЭЛХИЙН ЭНХ ТАЙВНЫ ТӨЛӨӨ

"Отгонтэнгэр" их сургуулийн Сэтгүүл зүй, олон улсын харилцааны тэнхимийн эрхлэгч, хэл шинжлэлийн ухааны доктор, дэд профессор Г.Жаргалсайхантай ярилцлаа.

Таны судалгааны ажлын зонхилох сэдвүүд Монголын түүх соёл, ёс заншил, мал аж ахуйн талаар байдаг. Тэр чанараараа таныг мал аж ахуйтай ойр өссөн болов уу гэсэн бодол төрлөө ...

-Аав минь удам дамжсан малчин хүн. Тийм болохоор монгол ахуйг мэднэ. Орчин цагт бид монгол ахуйгаас холдож байгаа дүр зураг ажиглагдах болсон. Суурин газрын хүүхдүүдэд энэ талын мэдлэг, мэдээлэл хомс. Үүнээс үндэслээд зааж байгаа хичээлээрээ дамжуулан хүүхэд, залууст зөв, цэгцтэй ойлголт өгөхийг зорьж ирсэн. Гэхдээ нэг их гүн гүнзгий нэвт судалчихсан зүйл алга. Уг нь би анхнаасаа хэл шинжлэлийн чиглэлээр судалгаа хийж байсан л даа.

**Урьд өмнө сонсож байгаагүй ч монгол хэлний үгсийн санд байдаг, аль эртнээс хэрэглэгдсээр ирсэн тийм үгстэй их таарах юм. Монгол хэлний үгсийн санд идэвхтэй хэрэглэгддэг хэдэн үг байдаг вэ?**

-Яг нарийн тоолсон зүйл байдаггүй. Харин нэрт эрдэмтэн Б.Ренчин хамгийн багадаа идэвхтэй хэрэглэгддэг гурван сая гаруй үг бий гэсэн. Судлаачид монгол хэлийг малчны хэл гэдэг дээр санал нэгдсэн. Өөрөөр хэлбэл монгол хэлний үгсийн сангийн дор хаяж 70 орчим хувь нь уугуул мал аж ахуйн амьдрал, соёлын өвийн шинжтэй үгс байдаг. Суурин газар, унаган ахуйгаасаа холдож өссөн зарим хүнд малчдын өдөр тутмын хэрэглээний үгсийн утга төдийлөн ойлгомжтой биш. Жишээлбэл, миний хичээл дээр сууж байсан нэгэн оюутнаас "Хуц, ухна хоёрыг эр, эм гэж ойлгоод байтал хонь, ямаа хоёр байсан юм уу" гэсэн онигоо маягийн шинжтэй яриа гарсан шүү дээ. Инээдтэй хэдий ч бодит байдал ийм л байна. Би малчны хотонд өсөөгүй учраас мэдэхгүй гээд цааргалаад байж болохгүй. Миний хувьд түүх, соёлын шинж чанартай зүйлсийг хэлээр дамжуулан илэрхийлэх, үргэлжлүүлээд монгол хэлийг соёл, ёс заншилтай нь барилдуулахад сургалт, судалгааны ажлаа чиглүүлсэн. Манай сургуулийн оюутны хэлснээр бол монгол хэлний багш нарыг болтгэхдээ хөдөө орон нутагт дадлага хийлгэх ёстой аж. Бас л сонирхолтой санаа. Яг ахуйд нь очиж байж нүдээрээ үзэж, илүүтэй мэдрэх нь хамаагүй үр дүнтэй байж болно. Жишээлбэл, эмээлийг өмнө харж байгаагүй, тодорхой дүр дүрслэлгүй бол цааш нь тайлбарлан таниулахад бэрх.

**Сүүлийн жилүүдэд малаа хариулахдаа морь биш, мотоцикл ашигладаг болсон. Энэ нь мал хариулах ёс болон малын тарга, тэвээрэгт сөргөөр нөлөөлөх үү?**

-Мал аж ахуйн симбиоз амьдрал гэж бий. Таван хошуу мал тавуулаа нэг нөгөндөө түшигтэй. Байгалиа мөн малчныхаа амьдралыг тэтгэж байдаг. Цагийн аясаар хүн гэдэг амьтан аливаа зүйлийн амрыг нь эрдэг болж. Гэхдээ машин, мотоциклоор мал элдэж хөөх нь маш сөрөг талтай. Мориор болон мотоциклоор харуулж байгаа малын амьдын жингийн хооронд хол зөрүү бий. Ийм төрлийн судалгаа ч байна. Малчин хүн чанга дуугарахгүй байж мал нь тайван амгалан болчиж тарга тэвээрэг авдаг онцлогтой. Гэтэл техникийн тэр их дуунд мал яаж тэсэх юм. Ер нь малыг малаар нь хариулах нь байгальдаа ч зохицдог.

**Манай улсын бэлчээрийн мал аж ахуй, нүүдэл бусад улсаас юугаараа онцлогтой вэ?**

-Бидний нүүдлийн онцлог нь байгальтайгаа хамгийн ойр, байгальд хор хөнөөл учруулдаггүй амьдралын эвшиллэлтэй. Нэг үгээр хэлбэл, байгалиа хамгаалж байдаг. Энэ нь бид бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэгтэй шууд холбоотой. Малчин хүн малтайгаа ойр байснаар бид нинжин сэтгэлтэй болдог. Учир нь мал чинь эзнээ үймрүүлнэ, баярлуулна, хүмүүжүүлнэ. Монгол хүний онцлог, үнэт зүйлээс тухайн хүн төлөвшиж байгаа юм болов уу гэж хувьдаа дүгнэдэг. Одоо жаахан хөндийрөөд байгаа нь ажиглагдаж байна. Малын бүх зүйл монгол хүний



биед зохицсон байдаг. Ганцхан мал гэхээр мах гэсэн ойлголт байж болохгүй. Хэрэглэхгүй орхидог зүйл нэг ч байдаггүй.

**Аргалын удвист чанарын талаар юу хэлэх вэ?**

-Аргалыг зөвхөн гэр орноо дулаацуулахад биш, хашаа хороогоо шавах, малын хэвтрийг дулаалах зэрэг олон янзаар хэрэглэдэг. Үүнээс гадна аргалын утаа агаарт байгаа олон нянг устгах чадвартай. Монгол мал өөрөө өвсний соргог, усны тунгалаг дагаж ургамлын хамгийн шим тэжээлтэй, зэрлэг дагшныг нь олж, шилж иддэг. Хортой өвсийг ялгаад хаяхчдаг.

**Бидний амьдарч байгаа энэ цаг үед соёлын довтолгоо маш олон сувгаар дамжин орж ирэх болсон байна. Энэ талаар ...**

-1948 онд улс ардын аж ахуйн соёлыг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөө батлагдсан байдаг. Тухайн үед бид суурин амьдралд дасаагүй, хөнгөлийн оронд бараг хөдсөн дээлээ хөдөрч унтдаг байж. Тухайн үеийн монгол ахуйг нийтийн соёлд дадуулах ажил гар нүүрийн алчуур, ор, хөнгөлийн цагаан хэрэглэл, оо, сойзтой болгохоос эхэлж байсан. Соёлын довтолгоо анх ингэж орж ирсэн. Монголчуудыг нийтийн соёлд маш хурдан сургасан ололттой тал бий. Одоо дангаарших, даяарших гэсэн хоёр ойлголтыг чухалчилж авч үздэг боллоо. Даяаршлын хувьд улс орнуудын зөвлөн хүчний бодлого ч гэж хэлэгддэг. Урлагаар дамжуулан өөрсдийн соёлыг нэвтрүүлэх нь их далайцтай болж ирлээ. Үүнд бид их бодлоготой, буурьтай хандах хэрэгтэй юм шиг санагддаг. Үзэж, харж болно. Түүнийг харин шууд нэвтрүүлэх эсэх дээр буурь заамаар. Монгол ахуйгаасаа холдчихсон байхад нь олон төрлийн кино, нэвтрүүлэг, контентуудаар хүүхэд, залуусын сэтгэлийг хөдөлгөхөд хэцүү зүйлгүй. Харин бид өөрсдийн гэсэн монгол ахуй, соёлоо сурталчилж таниулсан, их цаг хугацаа, том орон зай эзэлсэн монгол уран бүтээл, контентуудаар тэнцвэржүүлж болно. Гаднын соёлд бүрмөсөн уусаж, шингэмээргүй байна шүү дээ. Чухамдаа Монгол Улсын тусгаар тогтнол нь иргэдийн ухамсарт оршдог. Тиймээс соён гэгээрүүлэх үүргээ л илүү өндөр түвшинд гүйцэтгэх нь зөв болов уу. Хүн бүр л би монгол хүн учраас соёлын өвийг тэтгэж, хадгалагч гэсэн сэтгэлээр хандаад эхэлбэл асуудал нааштайгаар эргэн гэдэгт эргэлзэхгүй байна. Харин тийм үзэл санааг бид бага наснаас нь суулгаж өгөх үүрэгтэй. Ингэвэл итгэл үнэмшилтэй болно. Энэ үүрэг дан ганц монгол хэл, түүхийн багш нарынх биш. Иргэн бүрийн оролцоо чухал. Сүүлийн үед зарим сэхээтэн монголоо муулах үзэгдэл мэр сэр үзэгдэх болж. Чингис хааныг гэхэд л домгийн баатар мэтээр яриад байх жишээтэй. Монгол бичгийг нэн эртний, хэрэглэхэд тохиромжгүй, технологийн шаардлагад нийцэхгүй гэх зэрэг сөрөг сэтгэгдэл их байна. Гэтэл тэр шаардлагад нь нийцүүлэх гэсэн оролдлого хэд гарсан билээ дээ. Ингэхээр бодох зүйл их байна. Үндэстнээ үгүйсгэх үзлээс ангид байя. Бид цөөхүүлээ. Хүн нэг бүрийн зүрх үндэстний өвөрмөц, онцлог хэв шинжээ хадгалж үлдэхийн төлөө цохилдог байх нь чухал. Хадгалж үлдэж чадваас тэр нь дангааршил болно. Гаднын орнуудын соёлоос сайхан нь бий юу гэвэл бий. Гэхдээ бид тунг нь тааруулбал зохиистой.

**Хүний үүсэл гарал, түүхийн асуудал хөндсөнхийг Факс Монголикийн талаар мэдээлэл өгөхгүй юу? Ямартаа ч XIII зууны Их Монгол Улсын талаар ярих байх ...**

-Монголын энх гэж орчуулагддаг. Үндсэндээ 13-14 дүгээр зуунд холбогддог. Дэлхийн хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд бүтэн нэг зууны турш өнгөлсөн улс Монголоос өөр байхгүй. Дэлхий нийт түгжигдмэл, хаалттай, улс орнууд хэн хэндээ дайсагнах үзэлтэй тийм үед хоорондоо харилцах үүд хаалгыг нээж өгсөн. Үлгэрлэж хэлбэл, 16-хан настай шавилхан бүсгүй хасаг тэрэг дүүрэн алт ачаад, наран ургахаас жаргахуй хүртэл газарт айх аюулгүй явж болох тийм тайван цагийг авчирсан гэж болно. Хуучин цагт Монголын байлдан дагуулалтыг их муушааж, буруутгаж бичдэг байсан. Монголын морин туурай хүрсэн газарт, цусан далай урсаж, үнсэн нурам хийсдэг гэх мэт. Гэтэл тухайн үед цус урсаагүй дайн гэж юу байсан бэ. Энэ цус, үнс нурмын цаана энх тайвныг бий болгох хүсэл эрмэлзэл байсан нь лавтай. Одоо дэлхий нийтийн энх тайвны асуудлыг анх XIII зуунд монголчууд хөндөн тавьжээ гэж үзэх эрдэмтэд олон болсон. Өнөөдрийн даяаршлыг монголчууд бий болгосон гэж үзэх боломжтой. Тухайн үед өөрсдийн соёлоо хэн

байгалийн чанга шалгарлыг хүн төрөлхтний өмнө нүүрэлдүүлсэн байх нь ...

-1860-аад оны үед АНУ-ын хэсэг эрдэмтэд цаг уурын эрс тэс нөхцөл, гадаргын хувьд олон хэв шинжтэй ийм бүс нутагт хүн үүссэн байх боломжтой гэж үзсэн. Тэр бүс нутаг нь Төв Ази, Монголын нутаг дэвсгэр юм. Ийм онолын таамаглалыг тухайн үедээ дэвшүүлсэн байдаг. 1905 онд Эндриус, Мэтьюгийн хамтарсан экспедиц энэ талаар судалгаа хийсэн бөгөөд үүнээс хойш Монгол, Орос, Америкийн хамтарсан хээрийн шинжилгээний ангиуд Монголын нутаг дэвсгэрт ажилласан байдаг. Одоогийн тогтоосноор 800 гаруй мянган жилийн тэртээ Төв Ази, Монголд хүн үүссэн гэж үзээд байна. Ийм таамаглал, онолыг дэвшүүлсэн нь тухайн үеийн байгалийн шалгарлыг давах гэсэн оролдлого, зүтгэлээс оюун ухаант хүн үүссэн гэж үзсэн хэрэг. Орхоны Шаамарын хөндийгөөс олдсон эртний хүний эрүүний яс мөн Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуйн олдворууд гэдэг бий. Эдгээр нь 800 гаруй мянган жилийн тэртээх үед хамаардаг. Бас хүний генийн сан хадгалагдах боломжтой бүс нутаг гэж байдаг. Түүнд хүйтэн мөсөн агуй, далайн усны гүнийг хамаатуулж болдог аж. Энэ талаар судалсан ОХУ-ын эрдэмтэн Эрнэст Мулдашев Ховд аймгийн Хойд Цэнхэрийн агуйд генийн сан хадгалагдаж байна гэж хэлсэн байна лээ. Энэ бүгдээс харахад биологийн, ген фондын талаас мөн зүйлийн үүслийн онолоор ч хүн үүссэн байх боломжтой бүс нутаг нь манайх. Харин хүний үүслээс хойших цаг хугацаанд мөн Монголын нутаг дэвсгэрт хээрийн амьтныг анх удаа гаршуулсан гэдэг нь ч үнэн. Саяхан Монголын хамгийн нам дор цэгийг шинэчлэн тогтоогоод буй. Уг нь далайн түвшнээс дээш 553 метр бүхий зүүн өмнөд хэсэгт орших Хөх нууруудын хотгор байсан. Харин одоо баруун хэсэгт буюу Говь-Алтай аймгийн Алтай сумын нутагт бий гэж үзэх болж. Ингэснээр нэг бүс нутагт хамгийн өндөр, нам дор цэг орших боллоо. Энэ нь өнөөх эрс тэс уур амьсгалтай гэдгийг зүй ёсоор батлаад өгчиглөө.

**Хүний үүсэл гарал, түүхийн асуудал хөндсөнхийг Факс Монголикийн талаар мэдээлэл өгөхгүй юу? Ямартаа ч XIII зууны Их Монгол Улсын талаар ярих байх ...**

-Монголын энх гэж орчуулагддаг. Үндсэндээ 13-14 дүгээр зуунд холбогддог. Дэлхийн хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд бүтэн нэг зууны турш өнгөлсөн улс Монголоос өөр байхгүй. Дэлхий нийт түгжигдмэл, хаалттай, улс орнууд хэн хэндээ дайсагнах үзэлтэй тийм үед хоорондоо харилцах үүд хаалгыг нээж өгсөн. Үлгэрлэж хэлбэл, 16-хан настай шавилхан бүсгүй хасаг тэрэг дүүрэн алт ачаад, наран ургахаас жаргахуй хүртэл газарт айх аюулгүй явж болох тийм тайван цагийг авчирсан гэж болно. Хуучин цагт Монголын байлдан дагуулалтыг их муушааж, буруутгаж бичдэг байсан. Монголын морин туурай хүрсэн газарт, цусан далай урсаж, үнсэн нурам хийсдэг гэх мэт. Гэтэл тухайн үед цус урсаагүй дайн гэж юу байсан бэ. Энэ цус, үнс нурмын цаана энх тайвныг бий болгох хүсэл эрмэлзэл байсан нь лавтай. Одоо дэлхий нийтийн энх тайвны асуудлыг анх XIII зуунд монголчууд хөндөн тавьжээ гэж үзэх эрдэмтэд олон болсон. Өнөөдрийн даяаршлыг монголчууд бий болгосон гэж үзэх боломжтой. Тухайн үед өөрсдийн соёлоо хэн

нэгэнд хүчээр тулгаж байсангүй. Бусдыг шашин, гарал үүслээр нь хавчин гадуурхах үзэгдэл бас байгаагүй. Өөрсдийнхөө газар нутаг дээр төрөлх шашин, хэл, соёлоороо амьдрах боломжийг бүрэн олгодог байж. Жишээлбэл, Монголын "Хархорум" хотод гэхэд Буддын, Христосын, Лалын гээд бүх шашны сүм хийд байсан. Эдгээрээс юу дуртайгаа тахин шүтэх эрх нь нээлттэй. Одоо харахад энэ нь цэвэр ардчиллын шинжтэй байсан гэж үзэхэд болно. Эцсийн эцэст дэлхийн энх тайвны төлөө өөрсдийгөө зольсон ард түмэн нь монголчууд. Энэ ч утгаараа дэлхий нийтийн санал асуулгаар Чингис хааныг мянганы сод хүнээр тодорхойлсон шүү дээ. Энгийн жишээ гэхэд л улс гүрэнд удирдлагын хамгийн оновчтой тогтолцоо мөн дэлхий нийтийн энх тайвны сүлжээ, худалдааны зам, морин өртөөг бий болгож өнөөдрийн харилцаа холбооны суурийг тавьснаас гадна дипломат албыг бий болгоход гол үүргийг гүйцэтгэсэн. Дан ганц манайд биш дэлхийн түүхэнд хийсэн том эргэлт юм.

**Энэ жил сар шинийн баярыг тэмдэглэхгүй гэж тогтсон ч танин мэдэхүйн талаас нь мэдээлэл өгөх нь зөв болов уу?**

-Хуучин уламжлалт ёсондоо анчин, нүүдэлчин овог аймаг байх цаг үед Цагаан сар намрын баяр байсан аж. Хөхүүрийн ам цаашлаад хүйтний эрч нашилсан учраас сүү саалиа бэлдэж цагаан идээгээ хурааж авдаг байжээ. Нөгөө талдаа ангийн улирал хаяанд ирдэг. Энэ хоёрын нийлэмжээр цагаан идээний болон ангийн баяр гэж хэлэх боломжтой. Тухайн үедээ төр гэж байгаагүй учраас иргэний шинжтэй байснаа Их Монгол Улс байгуулагдах үед хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрөөс тэмдэглэдэг төрийн баяр болж хэвшжээ. Энэхүү баярын хоёр том ёсон байна. Нэгдүгээрт битүүний буюу битүүрэх ёсон гэж бий. Нэг жил дуусаж шинэ жил эхэлж байгаа тэр цаг үед битүүлж дүүрэх ёстой. Ингэснээр тухайн жилдээ элбэг дэлбэг байхыг бэлгэддэг. Мөн ангийн махнаас хувь хүртэх эрт цагийн ёс нь хадгалагдсаар ирэхдээ битүүлэх ёсон болсон гэж үзэх ч талтай. Үүнийг дагаад янз бүрийн зан үйл тогтсон байдаг. Жишээлбэл, өөлдүүдийн дотор битүүлэг гүйлгэх буюу үхрийн толгойг жиргээд өйр орчмын хүмүүст хувь хүртээдэг. Энэ нь өв тоног авах ёсноос эхтэй буюу дайснаа дарж дархан цолоо мандуулья, хуйхаа хувааж идье гэсэн санаа юм. Битүүний гол ёсолгоо нь ахмад настай айл нь залуу айлдаа орж битүүлдэг. Дутуу дундуураа дүүргэж байгаа хэрэг. Мэдээж шинийн нэгний өглөө ахмад настандаа түрүүлж золгох бөгөөд ёслолын хувьд цагаан идээгээр эхэлнэ. Зарим нутагт цагаалга гээд үзэмтэй будаа, аарцтай будаа тавьсан байдаг. Ингээд битүүний өдөр ангийн хувь хүртээх уламжлал сэргэсэн бол шинийн нэгний өглөө цагаан идээний баярын дурсамж сэдрэдэг онцлогтой. Ерөнхийдөө эрт цагийн онцлог, хэв маягийг ямар нэгэн байдлаар хадгалсаар өнөө цагтай золгоод байна. 1952 оноос сар шинийн баярыг түр цуцалснаас уламжлал бага зэрэг алдагдсан. Гэхдээ бага багаар сэргэж байгаа.

**Монголчууд Бурхны шашнаар бол шинийн 15-ны дотор засал номоо хийлгэх учиртай. Гэтэл шашнаас хамааралгүй байхад засал номыг юугаар орлуулдаг байсан нь их сонирхолтой санагдлаа ...**

-Том туульсыг хайлах, хуур татах, хүүхдийн даахь авах зэрэг нь засал номын шинжтэй байсан гэдэг. Намар цагт жилээ утгаж буюу сар

шинээс өмнө засал номоо хийлгэдэг байж. Тухайлбал, гал тахиулах зан үйл нь том засал номдоо тодорчдог. Галаа тахиулсан айл тухайн жилдээ алзахгүй.

**Та "Монгол угсаатны нэрийн үгийн сангийн онцлог" сэдвээр докторын зэрэг хамгаалсан. Судалгааны ажлынхаа талаар мэдээлэл өгөхгүй юу?**

-Судалгааны ажлынхаа хүрээнд Монгол гэдэг нэр болон Монголын газар нутагт байсан эртний төрт улсуудын болон угсаатны нэрс, наашаагаа 2000 оны тооллогын дүнгээр гарсан 27 ястан болон нийт 3200 овгийн нэрд утга зүйн ангилал хийсэн. Нэг хэсэг нь сайхан бэлгэдлээр өгсөн бол, нөгөө хэсэг нь хоч бөгөөд доромж нэрийн шинжтэй нэрс байна. Мөн уул, усны болон хүний нэр гээд янз бүрийн байдлаар тогтсон байна. Докторын ажлын суурь маань миний анхлан судалсан түүх, угсаатны зүй гэсэн судалгааны ажил байлаа. Түүнийгээ гүнзгийрүүлсэн хэрэг.

**Угсаатны бүлгийн ижилсэл гэж юу вэ?**

-Угсаатны ижилсэл гэдэг нь гарал угсаа нэгтгүүд хоорондоо нийлэхээр тодорхой цаг хугацааны дараа ялгаанууд нь арилж эхлэхийг хэлдэг. Хамгийн ойрын жишээ гэхэд л АНУ, Их Британид тийм зүйл тохиолдсон. Эсвэл хоёр өөр угсаатан хоорондоо ууссан байж болно. Ингэж ууссан тохиолдол гэвэл Хамниган Монгол, Хотон монгол, Казак Монгол, Чантуу монгол. Чингис хаан Их Монгол Улсыг байгуулснаар овгийн байгууллыг үндсээр нь халсан. Хооронд нь холиод нэгтгэгчээр би ийм, тийм овгийн хүн гэж хэлэх аргагүй болсон байх. Ингэж нийлэгшиж явсаар 1925 онтой золгосон байдаг. Угсаатны бүлгүүд XIII зууны үеэс үүсэж, XVII зуунд бүрмөсөн ялгарсан байдаг. Жишээлбэл, Буриад, дөрвөд, баяд, захчин, мянгад, хотон гэж ялгарсан. Ингэхдээ ажил үүргийн онцлогоос болсон юм билээ. Хорчин гэхэд л нум, сум хийж, сэлбэж засна. Хишигтэн нь цэргийн нэг бүлэг. Торгууд нь Чингис хааны торгон тодорхой улбаатай байх жишээтэй. Захчин гэвэл захын нутгийг сахисан харуулын хүмүүсээс үүсэлтэй гэх мэт. Дарьгангын тухайд л хоёр өөр газраас нэг газарт хамтран аж төрсөөр нэг угсаатны бүлэг болчихсон байна. Гэхдээ угсаатны бүлгийн ялгаагаа тодорхой хэмжээнд хадгалж үлдсэн байгаа юм. Мэдээж ялгаа нь удаан хадгалагдах тусам Монгол угсаатны дархлаа бат оршино гэсэн үг.

**1990-ээд оноос бид ургийн овгоо эргэн хөтлөх болсон. Гэтэл судалгаа, нотолгоогүй хандаж, сайн дураараа Боржигон болчихсон хүмүүс ч байна ...**

-1925 онд ЗХУ-ын Засгийн газрын шийдвэрээр тусгай тогтоол гарган монголчуудын ургийн овгийг эцгийн нэрээр солих болсон. Тухайн үедээ эмзэглэх зүйл байгаагүй, бид ч хүндээр хүлээж аваагүй юм билээ. Ингээд 1960-аад оноос хойш цус ойртох үзэгдэл ихэссэн. Энэ нь өнөөх ургийн овгийн нэрийг эцгийн нэрээр сольсонтой л холбоотой байгаа юм. Угаас бэсүд бэсүдтэйгээ суухгүй нь ойлгомжтой. Гэтэл ямар ургийн овогтой хүн гэдгийг нь, мөн өөрийнхөө овгийг ч мэдэхгүй тийм цаг үед тулаад ирсэн учраас асуудлыг эргэж харах шаардлага тулгарсан байх. Есөн үе улирсан тохиолдолд төрөл аглагшдаг. Ийм учраас 1990-ээд оноос ургийн овгийг сэргээх ажил өрнөсөн ч нэг ноцтой алдаа гарсан. Жишээлбэл, тухайн газар орон нутгаас хамаараад язгуур овгуудыг нь нэрлэнэ. Тэдгээр нэрсээс өөрийнхөө овгийг сэргээж чадахааргүй бол бусад овогс сонголт хийнэ. Энэ үед л Нууц товчооны Боржигон, Бэсүд зэрэг овог хүний нүдэнд их өртөж, сонгогдсон байх гэж боддог. Ургийн овгоо зөв хөтлөх нь цус ойртолтоос сэргийлнэ. Бид ургийн овогт нийгмийн үүрэг байгаа юу гэдэг асуудлыг хөндөж, овгоо зөв тогтоох ажлыг далайцтай хийх нь чухал. Гагцхүү есөн үеийн дотор хоорондоо гэрлэж болохгүй гэдгийн гэрч тэмдэг нь ургийн зөв хөтлөлт. Манайхны дотор гэхэд л хэд хэдэн өөр овог байна. Уг нь эртнээсээ "Захирагч" овогтой. Гэтэл одоо нэг эцгийн хүүхдүүд өөр өөр ургийн овогтой. Сайн мэдэхгүй хэрнээ хэсэг яриад суухаар төрөл садан шахуу болчихдог нь учиртай. Бид үүнийг эргэж харах нь зөв.

**Ярилцсанд баярлалаа. Таны цаашдын судалгааны ажилд амжилт хүсье.**

